

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн тайлан, бодлогын газруудаас гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 17 зорилтын 72 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2021 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /[unelgee.gov.mn/](http://unelgee.gov.mn/) цахим системд байршуулсан 17 зорилтын 72 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтад авагдсан 72 арга хэмжээний 42 арга хэмжээг яам толгойлон, 30 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба нийт 72 арга хэмжээний биелэлт 77.7 %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 66 арга хэмжээний биелэлт 77.2 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 86.7 хувь,

- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 70.0 хувь, хэрэгжүүлсэн нийт 72 арга хэмжээний биелэлтийг 77.7 хувьтай дүгнэлээ.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**  
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

| Зорилт  | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо |           |           |           |          |                | Хэрэгжилт /хувь/ |
|---|--------------|--------------------|---------------------------------------|-----------|-----------|-----------|----------|----------------|------------------|
|   |              |                    | 100                                   | 90        | 70        | 50        | 30       | Төлөвлөгдөөгүй |                  |
| Нэг.Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого | 1            | 1                  | 1                                     | 0         | 0         | 0         | 0        | 0              | 100.0            |
| Хоёр. Эдийн засгийн бодлого   | 11           | 66                 | 17                                    | 17        | 15        | 13        | 3        | 1              | 77.2             |
| Дөрөв. Засаглалын бодлого   | 3            | 3                  | 1                                     | 1         | 1         | 0         | 0        | 0              | 86.7             |
| Тав. Ногоон хөгжлийн бодлого  | 2            | 2                  | 0                                     | 0         | 2         | 0         | 0        | 0              | 70.0             |
| <b>Дүн</b>  | <b>17</b>    | <b>72</b>          | <b>19</b>                             | <b>18</b> | <b>18</b> | <b>13</b> | <b>3</b> | <b>1</b>       | <b>77.7</b>      |

**2021 оны зорилтот түвшиндээ хүрээгүй 3 арга хэмжээ байна. Үүнд:**

1. 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэсэн зорилтын 1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна, 7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна, 9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.

Эдгээр 3 арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй, боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувиар үнэлэгдлээ.

**2021 оны ямар нэг ажил хийхээр төлөвлөөгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:**

1. 3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ гэсэн зорилтын 3.2.1.6.2. Конвейерийн системийн хөрөнгө оруулалт арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2021 онд ажил төлөвлөөгүй ба 2022 оноос гүйцэтгэл гарч эхлэхээр байна.

**Дөрөв. Дүгнэлт.**

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 77.7 хувьтай дүгнэснээс 19 арга хэмжээ 2021 оны зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 18 арга хэмжээ гол үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 18 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 13 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн

буюу 50 хувь, 3 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 30 хувь, 1 арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх болоогүй буюу 2021 онд ажил төлөвлөөгүй байна.

2. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэйгээр хэрэгжилт удааширсан, хангалтгүй хэрэгжилттэй ажлууд нэмэгдсэн тул цаашид авах арга хэмжээнд анхаарч ажиллах шаардлагатай байна.

#### **Тав. Санал, зөвлөмж.**

1. Төрийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэгчээр тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг толгойлон хэрэгжүүлэх байгууллагаас гаргуулан авах, хэрэгжилт хариуцсан нэгжүүдтэй хамтран ажиллах албан хаагчдыг сонгож үүрэгжүүлэх шаардлагатай.

2. Салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж хэвших.

3. Нэгжүүд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, зорилго, зорилт нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилт, хүрэх үр дүнтэй хэрхэн уялдаж байгааг биелэлт гаргахдаа хамт тайлагнаж байх.

4. Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй яамны хариуцсан нэгжүүд нягт, уялдаа холбоотой ажиллах, мэдээлэл авах болон хүргэх нэгдсэн цонхтой болох, хэрэгжилтийг сар, улирлаар шинэчлэн авч хэвших шаардлагатай байна.


5. Зорилтот түвшиндээ хүрээгүй ажлуудын хэрэгжилтэд онцгой анхаарч тусгайлсан төлөвлөгөө гарган ажиллах.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Хянасан:  
ХШҮДАГ-ын дарга

  
Ц.Одхүү

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан/  
ХШҮДАГ-ын ахлах шинжээч

  
Х.Цэнд-Аюуш

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР



**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ  
2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР**

| №  | ЗГҮАХ-т тусгагдсан зорилт   | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт<br>Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр   |   | Хэрэгжилтийн хувь |
|--|---|---|------------------|---------------------------------|---|--|---|-------------------|
|  |   |   |                  |                                 |   | 2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт  | Хүрсэн түвшин, үр дүн   |                   |
|  |   |   | 4                | 5                               | 6   | 7  | 8   | 9                 |
| <b>НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b> |   |   |                  |                                 |   |  |   |                   |
| 1  | 1.1.6. Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. | 1. Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024      | ГХЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ЭТТ           | -   | Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. Нүүрс тээврийн жолооч нарыг БНХАУ-ын талын тусгаарлалтын бүсэд байршуулж, хонуулах ажлыг зохион байгуулж, нүүрс тээврийн жолооч нарыг дархлаажуулалтын вакцинд хамруулах | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2021.04.30-ны өдрийн 38 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайтын орд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, ногоон бүс болгох эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Шуурхай бүлгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдалаар ахлуулан байгуулсан. Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 38 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд шуурхай бүлгийн бүрэлдэхүүн 2021.05.01-ний өдрөөс 2021.05.07-ны өдөр хүртэл томилолтоор ажилласан. Улмаар Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй "Ногоон | 100               |

|                                     |   |  |             |                  |   |   |  |     |
|-------------------------------------|---|--|-------------|------------------|---|---|--|-----|
|                                     |   |  |             |                  |   |   | <p>гарц"-ын журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх санал хүргүүлэх тухай УУХУСайдын 2021.02.16-ны өдрийн 01/373 дугаар албан бичгийг ГХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Энэ хүрээнд Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг "Энержи ресурс" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны Улсын комисст хүлээлгэн өгч, улмаар 2021.10.03-ны өдөр "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Энержи ресурс" ХХК, "Тавантолгой" ХК-иуд бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээг байгуулсан. Терминалын үйл ажиллагааг 2021.11.08-ны өдрөөс эхлүүлэн өдөрт 100 тээврийн хэрэгслээр экспорт хийж эхэлсэн боловч 2021.12.15-ны өдрөөс эхлэн зогсонги байдалд шилжсэн. Шивээхүрэн боомтод 11.6 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг "Монголын алт (МАК)" ХХК, "Саусгоби сэндс" ХХК, "Хүрэн толгой коал майнинг" ХХК, "Өсөх зоос" ХХК, "Жавхлант орд" ХХК, "Цагаан өвөлжөө" ХХК "Сан транс" ХХК-иуд гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 орчим хувьтай байгаа бөгөөд БНХАУ-ын талд гацсан бараа бүтээгдэхүүнийг татан авч суурилуулах ажил хүлээгдэж байна. 2021 оны 12 дугаар сарын байдлаар 16.1 сая тн нүүрс, 1,282.5 мян.тн зэсийн баяжмал 7,106.2 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 644.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна.</p> |     |
| <b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b> |   |  |             |                  |   |   |  |     |
| 2                                   | 3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ. | 1. Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | "Оюу Толгой" ХХК | Далд уурхайд 1,298.96 сая.\$-ийн санхүүжилт хийсэн байна. 2021-2021 оны 12-р сарын 30-ныг хүртэл 777.24 сая.\$-ийн хөрөнгө оруулалт хийхээс | Далд уурхайн нэвтрэлт 43,222 экв.метр, газрын гадарга руу гарах туузан дамжуурга 14,981 экв.метр, далд уурхайн бүтээн байгуулалт 54%-д хүргэнэ. 2,003.56 сая.\$-ийн хөрөнгө | Оюу толгойн төсөлд 2021 оны байдлаар төсөл эхэлснээс хойш далд уурхайд 4,044.0 сая.\$-ийн санхүүжилт хийсэн. "Оюу толгойн ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай" Монгол Улсын Их хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 174 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 23 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг ажиллаж байна. Дээрх ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар, ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн  | 100 |

|  |  |  |  |   |                                     |  |
|--|--|--|--|---|-------------------------------------|--|
|  |  |  |  | <p>2021.11.30-ны өдрийн байдлаар 512.72 сая.\$-ийн хөрөнгө оруулалт хийсэн. /Гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээлээр/</p> | <p>оруулалт хийхээр төлөвлөсөн.</p> | <p>A/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Дээр дурдсан чиг үүрэг бүхий Ажлын хэсэг болон ажлын дэд хэсгүүд нь ажлын төлөвлөгөө, удирдамжид тусгагдсан чиглэлээр санал дүгнэлт гарган ажиллаж байгаа бөгөөд тус яамнаас Техникийн хамтарсан хэсэгт ажиллаж, холбогдох саналуудыг хүргүүлж ажилласан. Мөн тус яамнаас Ашигт малтмалын тухай хуулийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу “Оюутолгойн далд уурхайн хүдэр тээвэрлэх шугам /үе шат1/-ыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах” тухай техникийн ажлын хэсгийг 2021.02.05-ны өдөр ажиллуулж, Оюутолгойн далд уурхайг Улсын комисс ашиглалтад бүрэн хүлээж авах хүртэл үйлдвэрлэлийн зориулалтаар түр ашиглах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргаад байна. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ашиглалтад орох хугацаа хойшилж, зардал нэмэгдсэн асуудлаар мэргэшсэн шинжээч сонгон, хөндлөнгийн дүгнэлт гаргуулж, тайлагнах үүрэг бүхий “Тусгай хороо”-г “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Монголын талын санаачилгаар 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолоор байгуулсан. Тус хороонд ТУЗ дахь Монголын талын төлөөлөл хоёр гишүүн болон Туркойз Хилл Ресурс компани (ТРК)-ийн төлөөлөл хоёр гишүүн, нийт 4 гишүүнтэй байхаар тогтсон. Тусгай хорооны 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 7 дугаар хурлаар Оюу Толгой төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтын зардал хэтэрсэн, гүний уурхай ашиглалтад орох хугацаа хойшилсон асуудлаар хөндлөнгийн шинжээчдийн багийг сонгон ажиллуулсан. Тус багийн зүгээс 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдөр үйл ажиллагааны явцын тайланг танилцуулж, 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдөр шинжээчийн дүгнэлтийг хүлээлгэн өгсөн. Мөн тусгай хорооны 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар хурлаар Шинжээчдийн дүгнэлтэд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах багийг ажиллуулахаар шийдвэрлэж, “Peer review” дүгнэлтийг гаргаж, ирүүлсэн. Дүгнэлтээр Оюу толгойн менежментийн багаас зардал хэтэрсэн, хугацаа хойшилсон шалтгааныг геотехникийн нөхцөлөөс болсон гэдэг тайлбарыг өнгөрсөн хугацаанд өгч байсан боловч дэлхийн нэр хүндтэй шинжээчийн баг зардал хэтэрсэн, хугацаа хойшилсон нь геотехникийн хүндрэлээс болоогүй гэж дүгнэсэн байдаг. УУХҮ-ийн сайдын 2021 оны 11-р сарын 24-ны өдрийн А/284 тоот тушаалаар Оюу толгой төслийн анхдагч мэдээлэл, боловсруулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийж талуудын</p> |
|--|--|--|--|---|-------------------------------------|--|

|  |  |  |  |  |  |   |
|--|--|--|--|--|--|---|
|  |  |  |  |  |  | <p>мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс томилогдсон шинжээчийн хэсэгт техникийн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. 2021 оны 12-р сарын 13-ний өдөр Рио Тинто группийн Ерөнхий захирал Якоб Стаусхолмоос Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-эрдэнэд Монгол Улсын засгийн газраас тавьсан саналыг харгалзан хөрөнгө оруулагчдын Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсны үндсэн дээр дараах арга хэмжээг авахад бид бэлэн байна гэсэн захидал ирүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Оюу Толгой төслийн Монгол Улсын Засгийн Газрын эзэмшлийн 34 хувьд ногдох нийт 2.3 тэрбум ам.долларын өрийг 100 хувь тэглэх. Ингэснээр өмнө нь тооцоолж байсан 22 тэрбум ам.долларын өр үүсэхгүй, улмаар “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 34 хувь эзэмшлийн үнэ цэн нэмэгдэж, ногдол ашиг авах хугацаа наашлах;</li> <li>2. ДУББСТ болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г цуцалж дуусгавар болгох;</li> <li>3. Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн санхүүжилтэд хөндлөнгийн аудит оруулахыг зөвшөөрөх;</li> <li>4. Гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас хүртэлх нэмэлт зардлыг хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж Эрдэнэс Оюу Толгой ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх;</li> <li>5. “Оюу Толгой” ХХК-ийн засаглалыг сайжруулах байдлаар гүний уурхайн төслийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авч холбогдох зардлыг харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу “Оюу Толгой” ХХК төлөх;</li> <li>6. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулах;</li> <li>7. Төслийн байгаль орчин, нийгэм, засаглалыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах.</li> </ol> <p>Засгийн газраас Оюу толгой ордоос Монгол Улсын үр ашгийг хангуулах арга хэмжээний тухай тогтоолыг Улсын их хуралд өргөн барьж хэлэлцүүлээд байна.</p> <p>2021 оны 12-р сарын 30-ны байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-89%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-85%, далд уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл-49,943 экв.м, туузан дамжуургын малталт-13,851 экв.м, далд уурхайн бүтээн байгуулалт 78</p> |
|--|--|--|--|--|--|---|



|   |   |             |  |  |  |   |    |
|---|---|-------------|--|--|--|---|----|
| 3 | 2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ. | 2020 - 2024 | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ  | 322,939.3 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 13.1 %- ийг, зээлээр 86.9%- ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ) | Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100%-д, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 34%- д, засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 39%- д хүргэнэ. | хувьд хүрсэн.<br>2021 оны 12-р сарын 30-ний байдлаар "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ийн хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 75%-д, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%-д, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 82.5%-д, засварын механикийн заводын өргөтгөл шинэчлэлийн ажил 30%-д хүрсэн. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хий ажлын гүйцэтгэл 69.4%-д хүрсэн.  | 90 |
| 4 | 2.1. Мөчлөгт урсгалт тээврийн технологи   | 2020 - 2021 | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "3B TEC AUFBEREITUNGSSYSTEME" GmbH компани | 55,483.0 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 8%-ийг, зээлээр 92%-ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ)          | Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 52%-д хүргэнэ. Олборлолтын зардлыг бууруулна.  | Мөчлөгт урсгалт тээврийн технологи төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах гэрээг "3BTEC Aufbereitungssysteme" Ltd компанитай 2020.05.28-ны өдөр байгуулсан. Нарийвчилсан ТЭЗҮ-г 2021.05.10-нд бэлэн болгож ирүүлсэн. Гэрээний хугацаа 2021.11.19-ний өдөр дуусахаар боловч гүйцэтгэгч тал гэрээний хугацааг 2022 оны 7-р сар хүртэл сунгах албан бичиг ирүүлсэн. Талууд харилцан хэлэлцэж 2021 оны 11 сард гэрээний хугацааг сунгахаар тохиролцсон. Мөчлөгт урсгалт тээврийн технологи төслийн ажлын график төлөвлөгөөний дагуу 2021.08.13-наас 2021.09.26-ны хооронд ирэх байсан конвейрийн 2-р байгууламжийн металл хийцийн бараа материал болох 120 тонн ачаа 2021.09.20-нд ирсэн. Төслийн календарчилсан төлөвлөгөөний дагуу металл хийцлэлийн 2-р багц конвейрийн байгууламжийн 1-р ачаа 80 тонн, 3-р ачаа 120 тонн 2021.10.02-нд ирэх байсан нь Замын-Үүдийн гааль дээр гаалийн бүрдүүлэлт удаашралтай, хил хаасан зэрэг шалтгааны улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. Металл хийц үйлдвэрлэлийн | 90 |



|   |  |             |   |  |  |  |   |  |
|---|--|-------------|---|--|--|--|---|--|
|   |  |             |   |  |  |  | ажлын явц 100%, бутлуурын барилга байгууламжийн бүтээн байгуулалт 100%, туузан дамжуургын системийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт 100%-д тус тус дууссан. Харин металл хийцийн тээвэрлэлтийн ажлын явц 70%, механик тоног төхөөрөмж, бутлуурын байгууламжийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 95%-д, туузан дамжуургын системийн тоног төхөрөмжийн үйлдвэрлэл 90%-тай байна. Овоолгын хэсгийн металл хийц болон механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц 48%-тай. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 24%-ийн гүйцэтгэлтэй. Мөчлөгт урсгалт тээврийн технологи төслийн барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 100%-д тоног төхөрөмжийн үйлдвэрлэл явц 90%-д, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт угсралтын ажил 35%-д хүрсэн нь хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 75%-д хүрсэн байна. |  |
| 5 | 2.2. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр.       | 2019-2020   | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК | 1.44 сая.\$ буюу 4,108.8 сая.төг                               | Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100%. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулна. | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК 2020.05.08-ны өдөр 7/006-20 дугаартай "Ил уурхайн Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг шинээр барих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ" байгуулж ажил эхэлсэн. 2021.09.30-ны өдөр гэрээний хугацаа дууссан. "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК-ийн зүгээс гэрээний хугацааг 2021.12.31-ний өдрийг хүртэл сунгуулах хүсэлтээ ирүүлсэн. Тэсрэх бодисын үйлдвэрийн ажлыг энэ онд багтаан ашиглалтад хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй үйлдвэрийн барилга байгууламжийн угсралтын ажил явагдаж байна. Үйлдвэрийн барилга угсралтын ажил 80%-тай, инженерийн шугам сүлжээний ажил 90%-тай, эмульсийн тэсрэх бодисын шинэ үйлдвэр барих төслийн явц 90%-тай байна. 2021.12.25-нд туршилтаар анхны эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэхээр төлөвлөж байсан ч, ковид-19 цар тахлын улмаас Эрэн хотоос ирэх зарим тоног төхөөрөмж саатсан нь туршилтаар эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх ажил хойшлогдсон. 2022 оны 1-р улирлад ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. | 90  |  |
| 6 | 2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл | 2020 - 2023 | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "Jiangxi Naipu mining                 | 239,003.5 сая.төг<br>Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 34%-д хүргэнэ. Жилийн хүдэр боловсруулах                                   | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажлын зураг төслийг Jiangxi Naipu mining machinery and new materials Co.ltd гүйцэтгэсэн. Одоогийн байдлаар зураг төслийг Монгол Улсын стандартад хөрвүүлэх, экспертизээр оруулах, батлуулах ажлууд хийгдсэн. Уг төслийн инженер-геологийн судалгааны ажил дуусаж, суурийн бүтцийн экспертизийн дүгнэлт баталгаажуулах ажил хийгдсэн. Байгаль орчны  | 100   |  |

|   |   |             |  |  |   |   |    |
|---|---|-------------|--|--|---|---|----|
|   |   |             | machinery and new materials" Co.ltd, "FLSmidth Mongolia" ХХК | хөрөнгөөр 36%-ийг, зээлээр 64%-ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ)  | хүчин чадал 35 сая тонн хүртэл өсгөнө.  | үнэлгээний ажил хийгдэж, тайланг ирүүлсэн. Төлөвлөгөөний дагуу газар шорооны ажил хийгдэж, үндсэн тоног төхөөрөмжийн суурийг цутгаж байна. Төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тээвэрлэлтийг шуурхайлах, БНХАУ-аас гүйцэтгэгч компанийн төлөөлөгчид, ажилчдыг ирүүлэх чиглэлээр холбогдох яамтай хамтран ажиллаж байна. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн газар шорооны ажлын гүйцэтгэл 86%-д, бетон цутгалтын ажил 86%-д, төмөр хийц нийлүүлэлт 100%, барилгын сэндвич хийх ажил 67%-д, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 100%-д тус тус хүрээд байна. Хүдрийн агуулах барих төмөр хийцүүд хүлээгдэж байна. 2021 оны 12-р сарын 30-ний байдлаар баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 85%-д хүрсэн. 2021 онд баяжуулах үйлдвэр 32.65 сая тонн хүдэр баяжуулсан бөгөөд баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 2024 онд 100%-д хүрснээр хүчин чадал 35 сая тоннд хүрэхээр байна.  |    |
| 7 | 2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл | 2020 - 2024 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ                                       | 28,452.8 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 22%-ийг, зээлээр 78%-ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ) | Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийг 39%-д хүргэнэ. Уул уурхай, хүнд үйлдвэр болон бусад салбарын шаардлагатай бүтээгдэхүүн үйлдвэрлэн, бүс нутгийн болон Монгол улсын металл бүтээгдэхүүний зохих түвшний хэрэгцээг хангахуйц үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болох. | Засвар, механикийн заводын 2018-2031 оны өргөтгөл шинэчлэлийн урьдчилсан ТЭЗҮ 2020 онд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр батлагдсан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2021.04.02-ны өдрийн А/159 тушаалын дагуу Засвар механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ болон инженерийн зураг төслийг боловсруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо 2021.05.05-нд Засвар механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ болон инженерийн зураг төслийг боловсруулах тендер зарлаж, 2021.07.26-нд нээсэн. Тендерт Ди Ди Эй Жи ХХК шалгарч, 2021.08.24-ний өдөр 5/196-21 тоот гэрээ байгуулсан. Гэрээний үргэлжлэх хугацаа 6 сар. Гүйцэтгэгч Ди Ди Эй Жи ХХК-ийн төслийн багийн төлөөлөл 2021.09.06-09-ны хооронд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий механикийн хэлтэс болон Засвар, механикийн заводын инженер техникийн ажилтнуудын төлөөлөлтэй уулзалт хийж, заводын үйлдвэрлэлийн талбайд ажиллав. Мөн Ерөнхий захирлын нэгдүгээр орлогч бөгөөд Ерөнхий инженерийн 2021.10.11-ний өдрийн 159 дүгээр шийдвэрээр байгуулагдсан ТЭЗҮ хүлээн авах ажлын хэсэг Ди Ди Эй Жи ХХК-ийн ТЭЗҮ боловсруулах төслийн эхлэлийн тайланг 2021.10.14-15-ны өдрүүдэд хэлэлцэж хүлээн авсан. Төслийн | 90 |

|    |  |   |             |  |  |   |   |  |    |
|----|--|---|-------------|--|--|---|---|--|----|
| 8  |  | 3. Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглахад оруулна.   | 2021 - 2024 | "Эрдэнэ цагаан суварга" ХХК                        | 3.0 сая.сая.\$ буюу 8,535.84 /Өөрийн хөрөнгөөр/  | Бүтээн байгуулалтын ажил 69%-тай. Уулын баяжуулах үйлдвэрийн барилгын угсралтын ажлыг хийх, тоног төхөөрөмжийг тээвэрлэх, төслийн санхүүжилтийн гэрээ хэлэлцээрийг хийнэ. | ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэл 30 орчим хувьтай. Ажлын явц гэрээнд заасан график төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна. 2021 оныд 28.45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж засвар механикийн заводын өргөтгөл, шинэчлэл хийсэн. 2021 оны 12-р сарын 15-ний байдлаар засварын механикийн заводын өргөтгөл шинэчлэлийн ажил 30%-д хүрсэн. | Төсөл хэрэгжүүлэгч Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Ковид-19 цар тахлын улмаас төлөвлөгдсөн ажлууд хойшлогдож, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил өмнөх оны суурь түвшний хэмжээнд буюу 69% байна. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглахад оруулахаар төлөвлөж байна. | 70 |
| 9  |  | 4. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулна. | 2020 - 2024 | "Эрдэнэ Монгол" ХХК "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК | Урьдчилгаа төлбөрт 3,500.0 сая.төг Зээлийн шимтгэлд 416.0 сая.төг тус тус төлсөн. Гадаадын зээл тусламж /JBIC/ | "Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 100%, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36%-д хүргэнэ.                 | 2021 оны 12-р сарын 30-ны байдлаар Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 34%-д хүрсэн. 2021 оны 9-р сараас хойш үлдэгдэл хөрөнгө оруулалтын зээлийн асуудал шийдэгдээгүй байна.   | 70   |    |
| 10 |  | 4.1. "Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн   | 2020 - 2021 | "Эрдэнэ Монгол" ХХК "Багануур" ХК                  | Урьдчилгаа төлбөрт 4,468.0 сая.₮, Сангийн яамнаас  | "Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт  | Засгийн газрын 2018 оны 132-р тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд эрчим хүчний нүүрс олборлогч "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-ийн зардал бууруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, уурхайн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангуулахад техникийн   | 70   |    |



|    |  |   |             |                                      |   |   |   |    |
|----|--|---|-------------|--------------------------------------|---|---|---|----|
|    |  | шинэчлэл.   |             |                                      | 907.0 сая иен тус тус төлсөн.   | 100%-д хүрнэ. Уурхайн жилийн олборлолтын хүчин чадлыг 5.7 сая тонн-д хүргэнэ.   | шинэчлэл хийх түүнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Эрдэнэс Монгол ХХК, Японы олон улсын хамтын ажиллагааны банкны экспортын зээлийн шугамаар шийдвэрлэсэн. "Багануур" ХК-н 6.7 м³ шанаганы багтаамжтай экскаватор 1 ш, хөрс тээврийн 100 тн-ийн даацтай автосамосвал 6 ш, нүүрс тээврийн 60 тн-ийн даацтай автосамосвал 3 ш, бульдозер 2 ш, нийт 12 ширхэг тоног төхөөрөмжийг 29.78 тэрбум төгрөгийн зээлээр худалдан авсан. "Багануур" ХК-иас тус тоног төхөөрөмжүүдийн урьдчилгаа төлбөрт 4.5 тэрбум төгрөг, сангийн яамнаас 907.0 сая иен төлж 2020 оны 12 сард 9 тоног төхөөрөмжийг, 2021 оны 4, 5 сард 3 тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авсан. 2021 онд 33.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж хүчин чадлыг 5.7 сая тонн-д хүргэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан боловч Багануурын Цахилгаан станцын ашиглалтад орох хугацаа хойшлогдсон ковидын нөхцөл байдалтай холбоотойгоор хөрөнгө оруулалт хойшлогдоод байна. 2021 оны 12-р сарын 30-ны байдлаар Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50 хувьд хүрсэн.   |    |
| 11 |  | 4.2. Шивээ-овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалт. | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК "Шивээ-Овоо" ХК | Урьдчилгаа төлбөрт 3,062.0 сая.төг /Зээлийн шимтгэл, даатгал орсон дүнгээр/ | Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36%-д хүргэнэ. Парк шинэчлэлт хийж уурхайн жилийн олборлолтын хүчин чадлыг 2.04 сая тонн-д хүргэнэ. | Засгийн газрын 2018 оны 132-р тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд эрчим хүчний нүүрс олборлогч "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-ийн зардал бууруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, уурхайн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангуулахад техникийн шинэчлэл хийх түүнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Эрдэнэс Монгол ХХК, Японы олон улсын хамтын ажиллагааны банкны экспортын зээлийн шугамаар шийдвэрлэсэн. Дээрх JBIC төслийн хүрээнд 2 комацу PC1250 гидро экскаватор, 5 комацу HD465 технологийн автомашин нийлүүлэгдэж нийт 14.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2020-2022 оны төлөвлөгөөт хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг биелүүлэх, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж өвөлжилтийг давахад бодитой хувь нэмэр оруулж байна. Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 3.0 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд үлдэгдэл 11.9 тэрбум төгрөгийг компанийн борлуулалтын орлогоос 4 жилийн хугацаанд төлж барагдуулна. Дээрх JBIC төсөл бол Шивээ Овоогийн уурхайн хүчин чадлыг 2.0 сая тонны хэмжээнд нь барих техникийн шинэчлэл юм. Нүүрс борлуулалтын зах зээл тодорхой бус болж буурах магадлал байгаатай холбогдуулан нэмэлтээр хөрөнгө оруулалт хийгдээгүй бөгөөд | 90 |



|    |  |             |                      |   |   |  |    |
|----|--|-------------|----------------------|---|---|--|----|
|    |  |             |                      |   |   | өнөөдрийн байдлаар техник ашиглалт 90.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд өвлийн оргил ачааллын үед акталсан техник ашиглах, гаднын байгууллагаас техник түрээсэлж ажиллуулах замаар шийдвэрлэж байна. Ирэх жилүүдэд нүүрс борлуулалтын зах зээл нэмэгдэх үед хөрөнгө оруулалт техникийн шинэчлэлд зориулж 5.0 тэрбум орчим төгрөгийн санхүүжилт зайлшгүй шаардлагатай байна. 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр Шивээ Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн барих 200 мВт-ын ДЦС-ын урьдчилсан ТЭЗҮ-г батлуулсан. Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 34%-д хүрсэн.  |    |
| 12 | 5. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ. | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК |   | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 10%-д хүргэнэ. | Туршилт судалгааны ажил 15%, Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт 60%, дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 5%-д хүрсэн. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-д хүрсэн.  | 90 |
| 13 | 5.1. Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалт.   | 2020 - 2021 | "Эрдэнэс Монгол" ХХК | - | Лабораторийн туршилт хийлгэх ажлыг 100%-д хүргэнэ.  | Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 2021.03.15-ны өдрийн (Мон)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Энэ хугацаанд Асгатын ордоос авчруулсан дээж нь тус ордыг төлөөлөхүйц байж чадахгүй гэж үзэн тус ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах мэдэгдлийг SGSIMME MONGOLIA ХХК-д 2021.01.21-ний өдөр цахим шуудангаар өгсөн. Тайлбар: (Асгатын мөнгөний ордын ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тус уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх тендерт "Асгат Кент" ХХК шалгаран 2019.11.06~2019.12.25-ны хооронд дээж бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын даалгаварт тусгасан ажил үүргийн хуваарь, ажлын гүйцэтгэлийн тайлан зэрэгтэй танилцахад | 50 |

|    |   |             |                          |   |   |   |    |
|----|---|-------------|--------------------------|---|---|---|----|
|    |   |             |                          |   |   | Штольня 1~5 амнуудыг нээж чадаагүйн улмаас ордыг төлөөлөхүйц дээж авч чадаагүй, ажлын даалгаврын дагуу ажлууд бүрэн хийгдээгүй байна. Эндээс харахад уулын геологи техникийн нөхцөл нэн хүндрэлтэйн дээр цаг уурын нөхцөл байдлыг тооцоолоогүй зэрэг шалтгаанаас үүдэн ордыг бүрэн төлөөлөхүйц дээж бэлтгэхэд ихээхэн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байна.) Асгатын мөнгөний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлүүд "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжсэнээс хойш Асгатын ордын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж эхний ээлжинд ТЭЗҮ-ийн суурь судалгааны ажлуудыг хийх нь зүйтэй гэж үзэн 2019.11.06-25-ны өдрийн хооронд тус ордын уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх ажлыг эхлүүлсэн байна. Туршилт судалгааны ажил 15%-д хүрсэн. Цаашид далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийхэд уурхайн хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар 2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлээд байна. 2022 онд 211.0 сая төгрөгөөр далд уурхайн хэвтээ ам нээх, бэхэлгээ, агааржуулалт, гэрэлтүүлэг хийх, 250.0 сая төгрөгөөр хагас үйлдвэрлэлийн дээж бэлтгэх, 1039.0 сая төгрөгөөр хагас үйлдвэрлэлийн туршилт хийх төлөвлөсөн. Дээрх ажлууд хийгдсэнээр лабораторийн туршилт хийлгэх ажил 100 хувьд хүрнэ. |    |
| 14 | 5.2. Асгатын мөнгөний ордын зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт. | 2020 - 2022 | "Эрдэнэс Монгол" ХХК     | -   | Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт 61%.                                 | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулж "Стийл Айрон" ХХК шалгарч нөөцийн категорийг өнөөгийн нөөцийн ангилалд нийцүүлэх ажил боловсруулагдаж байна. Нөөцийн категорийг өнөөгийн нөөцийн ангилалд нийцүүлэх ажил хийгдсэн бөгөөд 2022 оны эхний хагаст ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулхаар төлөвлөгдсөн. Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт 60%-д хүрсэн. Ордын хэмжээнд 5000 га талбайд М 1:2000 гадаргын бүрэн зураглал хийх, тусгай зөвшөөрлийн хил хязгаар тогтоох шав тэмдэг тавих ажил цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-н чиглэлийн дагуу цуцлагдсан.   | 90 |
| 15 | 6. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж,        | 2021 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 16,058.4 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 5%-д хүргэнэ. | 2021 оны 12-р сарын 30-ны байдалаар уурхайд 86 тэрбум төгрөг бүхий 23 ш техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7%-д хүрсэн. Конвейерийн системийн олон улсын шаардлагад нийцсэн ТЭЗҮ, FEED боловсруулах тендер шалгаруулалтыг зарласан боловч хураангуй  | 70 |

|    |  |             |                          |   |   |   |  |  |   |  |  |
|----|--|-------------|--------------------------|---|---|---|--|--|---|--|--|
|    |  |             |                          |   |   | үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна. |  |  | Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулийн бүтээн байгуулалтын ажил 34%-д хүргэнэ. Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 40%-д хүргэнэ. 2021 онд нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн ажил 20%-д хүргэнэ.   | жагсаалт үүсээгүй тул 2021.11.02-ны өдөр дахин зарлаж, 11-р сарын 16-ны өдөр тендерийг нээсэн бөгөөд тендер шалгаруулалтын ажил үргэлжилж байна. Ажлын гүйцэтгэл 3%-д хүрсэн. Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 28%-д хүрсэн. Нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн ажил 10%-д хүрсэн. Нүүрс баяжуулах үйлдвэрийн бэлтгэл ажил 10%-д хүрсэн. |  |
| 16 | 6.1. 3.2.1.6.1. Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт. | 2020 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 11,241.2 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 5%-д хүргэнэ. |   |  |  | 2021 оны 12-р сарын 30-ний байдлаар уурхайд 86 тэрбум төгрөг бүхий 23 ш техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7%-д хүрсэн. 130 тн даацтай автосамосвал 12 ш, 12 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2ш, 7-8 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2ш, 13.7 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 10 м3 хутганы багтаамжтай дугуйт түрэгч 1ш, 8.5 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 4.3 м3 хутганы урттай автогрейдер 1 ш, тус бүр 20 м3 ёмкостой усны болон түлшний автоцистерн зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг худалдан аваад байна. Гэрээний дагуу техник тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдэж байгаа бөгөөд нийлүүлэлт хийгдсэн техникүүд уурхайд ажиллаж байна. | 90   |  |
| 17 | 6.2. 3.2.1.6.2. Конвейерийн системийн хөрөнгө оруулалт.      | 2021 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 3,500.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/  | 2021 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй.                         |   |  |  | 2021.09.10-ны өдөр "Конвейерийн системийн олон улсын шаардлагад нийцсэн ТЭЗҮ, FEED боловсруулах" ЭТТ/202102014 дугаартай нийт 3,500,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй Зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг зарласан боловч хураангуй жагсаалт үүсээгүй тул 2021.11.02-ны өдөр дахин зарлаж, 2021.11.16-ны өдөр тендерийг нээсэн бөгөөд тендер шалгаруулалтын ажил үргэлжилж байна. 2021 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй болно.   | /-/  |  |

|    |   |                |                                 |  |  |  |    |
|----|---|----------------|---------------------------------|--|--|--|----|
| 18 | 6.3. 3.2.1.6.3.<br>Нүүрс<br>баяжуулах<br>үйлдвэр        | 2021 -<br>2023 | "Эрдэнэс-<br>Тавантолгой"<br>ХК | 973,227.6<br>(10 сая.тн/жил<br>хүчин чадалтай<br>эхний блокийн<br>хөрөнгө<br>оруулалт) | Нүүрс<br>баяжуулах<br>үйлдвэрийн 1-р<br>модулын бүтээн<br>байгуулалтын<br>ажил 34%-д<br>хүргэнэ. | Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Чайна металлуржикал инженеринг компани" /СМЕС/ боловсруулж 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн ЭБМЗ-ийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. ЗГ-ын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай 113 дугаар тогтоол батлагдсан бөгөөд уг тогтоолд Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг ТЭЗҮ-ийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг УУХҮСайд болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-д даалгасан. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс "Чайна металлуржикал инженеринг" компанитай байгуулсан гэрээний дагуу 2 дугаар шатны ажил болох нүүрс баяжуулах үйлдвэрийн FEED буюу урьдчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 8 дугаар сард дуусган хүлээж авсан. 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956,447,866,100 төгрөгийн өртөг бүхий тендерийг зарласан бөгөөд 9 дүгээр сарын 27-ны өдөр нээсэн. Тендерийн хугацаанд нийт 20 газар тендерийн бичиг баримт авснаас ПАУЭР КОНСТРАКШН КОРПОРАЙШН ОФ ЧАЙНА, "Норинко Интернэшнл"ХХК, ЖУНГМЭЙ ИНЖЕНЕРИНГ ГРУПП, СИНОСТИЙЛ ЭКЬЮМЕНТ ЭНД ИНЖЕНЕРИНГ ГРУПП гэсэн 4 газар оролцохоор материалаа ирүүлсэн. Тендер шалгаруулалтын хүчинтэй хугацаа дуусгавар болсон учир амжилтгүй болсон. Улмаар 2021 оны 11 сарын 15-ны өдөр дахин тендер зарласан бөгөөд 12 сарын 15-ны өдөр материал хүлээн авч, дотоод хяналтын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн. Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил удааширсан. Ковид-19 цар тахлын улмаас зорилтод түвшиндээ хүрээгүй. | 50 |
| 19 | 6.4. 3.2.1.6.4.<br>Ачилтын<br>нэгдсэн төв<br>байгуулах. | 2021 -<br>2022 | "Эрдэнэс-<br>Тавантолгой"<br>ХК | 217,500<br>/Төрийн өмчит<br>компанийн<br>санхүүжилтээр/                                | Ачилтын<br>нэгдсэн төв<br>байгуулах ажил<br>40%-д хүрэх.   | Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн талаар авах арга хэмжээний тухай 2021.04.07-ны өдөр батлагдсан 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ТУЗ-өөс 2021.05.17-ны өдөр 20 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолд заасны дагуу Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв /салбар төмөр зам, ачих байгууламж/-ийн техник, эдийн засгийн үндэслэл,   | 70 |



|    |   |  |             |                             |   |   |   |     |
|----|---|--|-------------|-----------------------------|---|---|---|-----|
|    |   |  |             |                             |   | зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулах, магадлуулах, барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хүлээлгэн өгөх ажлыг төмөр замын тусгай зөвшөөрөл бүхий өөрийн охин компани болох "Тавантолгой төмөр зам" ХХК-аар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхтэй холбоотой "Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн санхүүжилтийн гэрээг 2021.07.09-ний өдөр байгуулсан. ТЭЗҮ-ийн судалгаа хийх түүнийг магадлуулах, барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ хийх зэрэг бэлтгэл ажлын хүрээнд 2.2 тэрбум төгрөгийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д шилжүүлсэн. Мөн ЭТТ бондын 2-р транчаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөс төслийн ажлыг эрчимжүүлэх, үндсэн байгууламжийн урьдчилгаа төлбөрт шаардлагатай 63 тэрбум төгрөгийг 2021.09.06-ны өдрийн нэмэлт гэрээний дагуу шилжүүлсэн. Төслийн ТЭЗҮ боловсруулах ажил дуусаж УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн хурлаар 2021.11.24-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан ба төслийг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай 15.8 тэрбум төгрөгийг ТЭЗҮ-д тусгагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу шилжүүлсэн. Тоног төхөөрөмжийн захилга хийгдэж ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 28 хувьд хүрсэн. Ковид-19 цар тахлын улмаас тоног төхөөрөмж орж ирээгүй, барилга байгууламж тоног төхөөрөмжийн суурилуултын ажил хойшлогдсон нь зорилтод түвшиндээ хүрээгүй. |   |     |
| 20 |   | 6.5. 3.2.1.6.5. Усан хангамж шийдвэрлэх.               | 2021 - 2023 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК    | 71,931.4 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Усан хангамжийн ажил 20%-д хүргэнэ.   | Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой" гүний усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг боловсруулж, Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулах ажлыг хийж байна. Загийн усны ус татах шугам хоолойн санхүүжилтийг компанийн 2022 оны төсөвт тусгаж барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 50  |
| 21 | 3.2.2. Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, | 1. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж | 2021 - 2024 | "Эрдэнэс силвер ресурс" ХХК |   | 2021 оны 6-р сард жилд 600 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай   | Үнэт цаас гаргагч "Эрдэнэс Монгол" ХХК нь үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг "Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль"-ийн хүрээнд зарцуулалт хийж, арилжааны банкуудтай гэрээ хийж 228,493.0 иргэн 6 сая төгрөг, түүнээс доош   | 100 |

|    |   |   |             |                       |   |  |  |     |
|----|---|---|-------------|-----------------------|---|--|--|-----|
|    | экспортын хэмжээг нэмэгдүүлнэ:                  | ашиглана.   |             |                       |   | шинээр баяжуулах үйлдвэр-II барьж ашиглалтад оруулах. 7-р сараас Салхит ордыг төслийн хүчин чадалд хүргэж ажиллах.   | дүнтэй зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөж (үүний 43,892.0 иргэн 1 сая төгрөг хүртэлх зээлтэй), 194,807 иргэн 1 сая төгрөгийн 2021.05.21-ний өдөр мөнгөжүүлсэн үнэт цаас эзэмшүүлэх замаар байгалийн баялгийн өгөөжөөс хүртээсэн. (Нийт 423,300 тэтгэвэр авагч иргэн). Жилд 600 мянган тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэр-II төслийг хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 90%, угсралт суурилуулалт 80%, барилгын материалын татан авалт 90%, барилга угсралтын ажил 80%, дэд бүтцийн ажил 80%. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2021 онд 46.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж Салхитын мөнгөний ордын баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажил 20 хувь, нэмэлт хайгуулын ажил 100 хувьд хүргэхээр төлөвлөсөн. 2021 оны 12-р сарын 15-ний байдлаар Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэх ажил 80%. Салхитын мөнгөний ордын нөөцийг нэмэгдүүлж, ордын насжилт өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны хайгуулын ажлын хүрээнд хийгдсэн геологи хайгуулын нарийвчилсан ажлын үр дүнд ордын нөөцийг бодитой ба боломжтой /B+C/ зэрэглэлээр 3,169,815.5 тонн хүдрийн нөөцийг ЭБМЗ-ийн 2021.04.15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн. |     |
| 22 |   | 2. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | Монголросцветмет ТӨҮГ | Нийт 39.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас 2021 онд 8.9 тэрбум төгрөг төлөвлөсөн. | Далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОНУ зэрэг шаардлагатай баримт бичгийг боловсруулж, холбогдох зөвшөөрлүүдийг авах. Далд уурхайг налуу амаар нээн 120 м малталт нэвтрэх. | Далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННУ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгал орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг боловсруулан батлуулсан. Цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан. Уурхайн налуу ам 80 м нэвтэрсэн ба 2021 оны эцэст нэвтрэлтийн хэмжээ 120м-130м-т хүрсэн. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. 2021 оны 12-р сарын байдлаар Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 20 хувьд хүрсэн.   | 100 |
| 23 | 3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, | 1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий           | 2021 - 2024 | УУХҮЯ                 | Улсын төсөв Гүйцэтгэл: 11,913.3 Санхүүжилт: 11,913.3                                  | Нутаг дэвсгэрийн 43%-ийг хамруулах, ашигт  | Цахир мушгиа уул-50, Олон гол-50, Номгоны нуруу-50, Худгийн нуруу-50 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Ингэснээр 14,278.29 км <sup>2</sup> талбай буюу 0.91%, нийтдээ 41.97%-ийг судалгааны ажилд хамруулаад байна. Эдгээр 4 төслийн судалгааны үр   | 90  |

|   |  |  |  |  |  |  |
|---|--|--|--|--|--|--|
| <p>судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.</p> | <p>эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулна</p> |  |  |  | <p>малтмалын хэтийн төлөвтэй 15 талбай ялгана.</p> | <p>дүнд алтны шороон илрэл Хуурай сайр (P2 зэргээр 224.19 кг), Угалзын худаг (P2 зэргээр 1524.1 кг), Дөшийн ам (P3 зэргээр 80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (P1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (P1 зэргээр 26.1 сая тн) зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй 20 талбайг ялгасан.</p> <p>Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалан 2020 оны 11-р сараас эхэлсэн бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн онцгой нөхцлөөс хамаарч төслүүдийн үр дүнгийн тайлан боловсруулах ажил удааширсан тул Сүүжийн говь-50, Цайлангийн нуруу-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Их Өлзийт-50 төслүүдийн хугацааг УУХҮСайдын 2021.02.04-ний өдрийн А/20 дугаар тушаалаар 3-6 сарын хугацаатай сунгасан. Дээрх нөхцөлтэй холбоотойгоор нутаг дэвсгэрийг хамруулах 2021 оны зорилтот түвшинд хүрээгүй болно.</p> <p>Төлөвлөгөөт онд 33 төслийн хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.</li> <li>2. Үргэлжлэн хэрэгжих 23 төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.24, 2021.03.25, 2021.03.26, 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021 оны тушаалаар баталгаажуулсан.</li> <li>3. Улсын тусгай хэрэгцээний газарт судалгаа хийх Дөч гол-50, Өндөр ширээт-50, Борзонгийн говь-50, Зангат-50, Гилбэнт уул-50, Хайрхан овоо-50, Овоот толгой-50, Хар хайрхан-50, Их элээт уул-50, Их бэрх уул-50, Улаангом-50, Уушгийн улаан-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Торлог уул-50 төслүүдийн гүйцэтгэгч нарт дэмжлэг үзүүлэх талаар УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, хилийн бүсэд хэрэгжүүлэх Дөч гол-50, Борзонгийн говь-50, Зангат-50, Гилбэнт уул-50, Торлог уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Их бэрх уул-50, Овоот толгой-50, Хар хайрхан-50 төслүүдийн гүйцэтгэгч нарт дэмжлэг үзүүлэх талаар ТНБДаргын</li> </ol> |
|---|--|--|--|--|--|--|

|    |  |             |       |  |   |   |     |
|----|--|-------------|-------|--|---|---|-----|
|    |  |             |       |  |   | <p>2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т тус тус хүргүүлэн гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>4. 2021 онд хэрэгжих төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг боловсруулан ТНБДаргын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулан шуурхай хяналтыг гүйцэтгэсэн. Мөн төслүүдийн хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021 оны 11 дүгээр сард хүлээн авч гүйцэтгэлийг хянасан.</p> <p>5. Шинээр хэрэгжүүлэх Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Ямаат уул-50, Загал уул-50, нийт 4 төслийн геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайдаар 2021.03.15-ны өдөр батлуулсан. 4 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдүүдтэй Захиалагчаас өгсөн үүргийн дагуу 2021.06.11-ний өдрийн 14, 15, 16, 2021.07.22-ны өдрийн 25 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.</p>  |     |
| 24 | 3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна | 2021 - 2023 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 1,749.5<br>Санхүүжилт: 1,749.5 | L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 40%-ийг хамруулна. | <p>Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1%-ийг хамарсан К хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.</p> <p>Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг L, M (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх 2 төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг 2021.03.25-ны өдөр хэлэлцсэн ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.05.20-ны өдрийн А/121, А/123 дугаар тушаалаар баталсан.</p> <p>Улсын тусгай хэрэгцээний газар болон хилийн бүсэд судалгаа хийх төслийн гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлэх талаар УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, ТНБДаргын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т тус тус хүргүүлсэн.</p> <p>2021 онд үргэлжлэн хэрэгжих 2 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг боловсруулан ТНБДаргын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан. Үргэлжлэн хэрэгжих төслүүдийн хээрийн судалгааны ажил цар тахлын хөл хорио, вакцинжуулалттай холбоотойгоор 2021.06.10-наас эхэлснээр L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 40%-ийг хамруулсан.</p> | 100 |



|    |  |             |       |  |   |  |     |
|----|--|-------------|-------|--|---|--|-----|
| 25 | 4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулна | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 2,153.6<br>Санхүүжилт: 2,153.6 | Ховд-2020 төслийг үргэлжлүүлэх, нутаг дэвсгэрийн 63.1%-ийг судалгааны ажилд хамруулна.  | Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг төлөвлөгөөт онд эхлүүлэхээр Ховд-2020 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар баталсан.<br>Ховд-2020 төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг 2021.03.25-ны өдөр хэлэлцсэн ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.05.20-ны өдрийн А/122 дугаар тушаалаар баталсан.<br>Төлөвлөгөөт онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг хийж дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 65%-ийг судалгаанд хамруулаад байна.   | 100 |
| 26 | 5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулна                  | 2021 - 2022 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 1,160.9<br>Санхүүжилт: 1,160.9 | Геохими-2019 төслийг үргэлжлүүлэх, нутаг дэвсгэрийн 80%-ийг судалгааны ажилд хамруулна. | 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км <sup>2</sup> талбайд буюу 32.1%-ийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нутаг дэвсгэрийг уг төслийн ажилд 100% хамруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж эхэлсэн.<br>2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км <sup>2</sup> буюу 67.9%-ийг хээрийн судалгаанд хамруулж дууссан. Энэ хүрээнд 2021 онд дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:<br>Төлөвлөгөөт онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнд хамруулахаар төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн.<br>Төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг 2021.03.29-ний өдөр хэлэлцсэн ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.05.20-ны өдрийн А/139 дугаар тушаалаар батлан шуурхай хяналтыг гүйцэтгэсэн.<br>Улсын тусгай хэрэгцээний газар болон хилийн бүсэд судалгаа хийх Геохими-2019 төслийн гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлэх талаар УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, ТНБДаргын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т тус тус хүргүүлсэн. | 90  |
| 27 | 6. Бүс нутаг болон хотуудын геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны  | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 1,255.3<br>Санхүүжилт: 1,255.3 | Эрдэнэт, Дархан хотын суурьшлын бүсэд судалгааны ажлыг хийх, Ховд хотод                 | Төлөвлөгөөт онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан хотын геозкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геозкологи-2019, ДА геозкологи-2020 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлан ажлыг хэрэгжүүлсэн.<br>Төслүүдийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг  | 100 |

|    |  |   |             |       |  |   |   |    |
|----|--|---|-------------|-------|--|---|---|----|
|    |  | ажил хийнэ  |             |       |  | шинээр судалгааны ажлыг эхлэнэ.   | <p>2021.03.25, 29-ний өдөр хэлэлцсэн ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.05.20-ны өдрийн А/124, 140 дүгээр тушаалаар баталсан.</p> <p>ДА геозкологи-2020 төслийн хээрийн судалгааны ажил гүйцэтгэхтэй холбогдуулан эзэмшлийн талбайд нэвтэрч дээжлэлт хийхэд дэмжлэг үзүүлэх тухай ТНБДаргын 2021.06.03-ны өдрийн 03/1408 дугаар албан бичгийг “Шарын гол” ХК, “Дархан дулааны цахилгаан станц” ТӨКХ, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Эрэл цемент” ХК, “НИК” ХХК-ийн Дархан НХСалбарын захиргаанд тус тус хүргүүлсэн.</p> <p>Шинээр хэрэгжүүлэх Ховд геозкологи-2021, Гүний хагарал-1 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2021.03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан. Гүний хагарал-1 болон ХО геозкологи-2021 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй 2021.06.11, 2021.07.21-ний өдрийн 17, 24 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.</p>  |    |
| 28 |  | 7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 448.4<br>Санхүүжилт: 448.4 | Тектоник, минерагенийн зураг зохиох /Тек-2021/ болон геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц /ГЗ-2021/ сэдэвчилсэн судалгааны ажлыг эхлүүлнэ. | <p>Монгол орны нутаг дэвсгэрийг хамарсан металлогений зураг зохиох Мета-2014 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн УУХҮСайдын 2021 оны А/225 дугаар тушаалаар хүлээн авсан.</p> <p>Төлөвлөгөөт онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагений судалгааны Мезо-Кайнозой-2021 болон босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2021 төслийг хэрэгжүүлэхээр 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг 2021.03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.</p> <p>Мезо-Кайнозой-2021 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй 2021.07.07-ны өдрийн 21 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.</p> <p>- Гео орчин-2021 төслийн тендер 2 удаа амжилтгүй болсон тул 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2022 оны УУХҮСайдын төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулан шийдвэрлэсэн.</p> <p>Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:500000-ны масштабын тектоникийн зураг зохиох ажлын бэлтгэлийг хангах хүрээнд 2021 онд тектоникийн схем боловсруулах хэсгийг ТНБДаргын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар баталж Үндэсний геологийн алба хариуцан</p> | 90 |

|    |   |  |             |       |  |  |  |     |
|----|---|--|-------------|-------|--|--|--|-----|
| 29 |   | 8. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ                 | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 126.4<br>Санхүүжилт: 126.4 | ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлыг эхлүүлнэ.           | хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан төслийн 4-р үе шатны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2021.06.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Тус зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХУСайдын А/217 дугаар тушаалаар төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан<br>МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан төслийн 5-р үе шатны ажлыг хэрэгжүүлэхээр 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг 2021.03.15-ны өдөр УУХУ-ийн Дэд сайд баталсан.<br>Төслийн төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй 2021.07.21-ний өдрийн 23 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.  | 100 |
| 30 | 3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ. | 1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 0<br>Санхүүжилт: 0         | Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн төрөлжсөн мэдээллийн сан төслийг эхлүүлэх, ажлын явц 30%. | Геомэдээлэл-2019 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2021.06.24-ний хуралдаанаар хамгаалсан. Тус зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХУСайдын 2021.08.11-ний өдрийн А/216 дугаар тушаалаар төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан.<br>Төлөвлөгөөт оноос хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг 2021.03.15-ны өдөр УУХУ-ийн Дэд сайд баталсан. Төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулахаар үнэлгээний хороог ТНБДаргын 2021.03.15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна.<br>Геологийн баримт-1 төслийн тендер 1 удаа амжилтгүй болсон бөгөөд Үндэсний геологийн албанаас Тагнуулын ерөнхий газарт хандан геологийн мэдээллийг боловсруулах энэхүү төслийг өөрсдийн хүчээр хийх хүсэлт гаргасантай холбогдуулан тендерийг зогсоосон. Гэрээ шууд байгуулах ҮГА-ны албан хүсэлтэд төрийн нууцтай холбоотой мэдээллийг боловсруулах хуулийн этгээдээр аюулгүй байдлын гэрчилгээ гаргуулан гүйцэтгүүлэх боломжтой гэсэн хариуг Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн. Холбогдох хууль, ТЕГ-ын албан бичгүүдийг судлан уг төслийг 2021 онд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэр гарсан. Учир нь ҮГА-нд хадгалагдаж байгаа геологийн мэдээлэл нь төрийн нууцын жагсаалтад байхгүй бөгөөд албаны нууцтай холбоотой мэдээллийг ашиглан үйл ажиллагаа явуулах хуулийн | 70  |



|    |   |             |       |  |   |  |    |
|----|---|-------------|-------|--|---|--|----|
|    |   |             |       |  |   | <p>этгээдтэй тендерийн хуулийн 3.4 дахь заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах боломжгүй болсон. Энэ асуудлын хүрээнд УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.11.25-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/95 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр геологийн мэдээллийн санг нэгтгэх, бүрдүүлэх зорилго бүхий төслийг 2021 оноос шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэх боломжтой эсэх асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Шууд гэрээ байгуулсны дараа үүсч болзошгүй нөхцөл байдал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4-т заасныг үндэслэн гэрээ байгуулахаас өмнө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс геологийн мэдээллийн сантай холбоотой хэрэгжүүлэх төслүүдийн талаар тус зөвлөлд албан бичгээр хандаж зөвлөмж авсны үндсэн дээр гэрээ байгуулахаар ажлын хэсэг шийдвэрлэсэн. 2021 онд гэрээ байгуулахад санхүүгийн жил дуусч байгаатай холбогдуулан гүйцэтгэл гарах хугацаа хангалттай бус байна гэж үзсэн санал гаргасан. Геологийн баримт-1 төслийг 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2022 оны УУХҮСайдын төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулсан.</p> |    |
| 31 | 2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 0<br>Санхүүжилт: 0 | Геологийн чулуун дээжийн сан болон цахим архив бүрдүүлэх төслийг эхлүүлэх, ажлын явц 30%. | <p>Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн хүрээнд Чулуун дээжийн сан-1 болон Цахим архив-1 төслийг хэрэгжүүлж эхлэхээр 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайдын 2021.03.15-ны өдрийн тушаалаар тус тус баталсан.</p> <p>Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар үнэлгээний хороог ТНБДаргын 2021.03.15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна. Чулуун дээжийн сан-1 болон Цахим архив-1 төслийн тендер 1 удаа амжилтгүй болсон бөгөөд Үндэсний геологийн албанаас Тагнуулын ерөнхий газарт хандан геологийн мэдээллийг боловсруулах энэхүү төслийг өөрсдийн хүчээр хийх хүсэлт гаргасантай холбогдуулан тендерийг зогсоосон. Гэрээ шууд байгуулах ҮГА-ны албан хүсэлтийн хариуд "төрийн нууцтай холбоотой мэдээллийг боловсруулах хуулийн этгээдээр аюулгүй байдлын гэрчилгээ гаргуулан гүйцэтгүүлэх боломжтой" гэсэн тайлбарыг Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн. Холбогдох</p>   | 70 |



|    |   |   |             |       |  |   |   |    |
|----|---|---|-------------|-------|--|---|---|----|
|    |   |   |             |       |  |   | хууль, ТЕГ-ын албан бичгүүдийг судлан уг төслийг 2021 онд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэр гарсан. Учир нь УГА-нд хадгалагдаж байгаа геологийн мэдээлэл нь төрийн нууцын жагсаалтад байхгүй бөгөөд албаны нууцтай холбоотой мэдээллийг ашиглан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдтэй тендерийн хуулийн 3.4 дахь заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах боломжгүй болсон. Энэ асуудлын хүрээнд УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.11.25-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/95 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр геологийн баримтын архивын үйлчилгээг цахимжуулах, чулуун дээжийн санг шинэчлэх, баяжуулах зорилго бүхий 2 төслийг 2021 оноос шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэх боломжтой эсэх асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Шууд гэрээ байгуулсны дараа үүсч болзошгүй нөхцөл байдал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4-т заасныг үндэслэн гэрээ байгуулахаас өмнө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Цахим архив-2021, Чулуун дээжийн сан-1 төслүүдийн талаар тус зөвлөлд албан бичгээр хандаж зөвлөмж авсны үндсэн дээр гэрээ байгуулахаар ажлын хэсэг шийдвэрлэсэн. 2021 онд гэрээ байгуулахад санхүүгийн жил дуусч байгаатай холбогдуулан гүйцэтгэл гарах хугацаа хангалттай бус байна гэж үзсэн санал гаргасан. Цахим архив-1, Чулуун дээжийн сан-1 төслийг 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2022 оны УУХҮСайдын төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулсан. |    |
| 32 | 3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал | 1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 457.1<br>Санхүүжилт: 457.1 | ГАСАМ төслийн үр дүнгийн тайланг хүлээн авах, ГХЭ-ийн хэтийн төлөвийн судалгааг эхлэнэ. | Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар баталсан. Төслийн 2021 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг 2021.03.29-ний өдөр хэлэлцсэн ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.05.20-ны өдрийн А/137 дугаар тушаалаар батлан суурин судалгааны ажлыг эхлүүлсэн. Стратегийн ашигт малтмалын төрлүүдийг тектоник, металлогени болон бусад геологийн хүчин зүйлс, дэд бүтэц зэрэг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдтэй хамтатган судалж, өнөөдрийн нөхцөлд стратегийн ашигт малтмал гэж авч үзэх төрлүүдийг бүсчилсэн хөгжлийн үзэл  | 50 |

|    |  |             |       |  |  |  |    |
|----|--|-------------|-------|--|--|--|----|
|    | болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.                                  |             |       |  |  | баримтлалд нийцүүлэн тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт өгөх, энэхүү судалгааны үр дүнд дэлхийн түүхий эдийн зах зээл дээр эрэлт ихтэй өндөр технологийн болон энергийн түүхий эдийг нарийвчлан судалж, Монгол Улсын экспортын чиг хандлагыг тодорхойлох суурь судалгааны ажлын үр дүнг цар тахлын нөлөөнөөс шалтгаалан 2021 онд хүлээн авах боломжгүй болсон.<br>Төлөвлөгөөт оноос хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайдын 2021.03.15-ны өдрийн тушаалаар баталсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн 2021.07.07-ны өдрийн 22 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.<br>“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг газрын ховор элемент, литий-цезийн төрлөөр боловсруулах ажлыг АМЕР-2 төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ГУУС-ийн харьяа Эрдэс баялгийн судалгаа, геомэдээллийн сургалтын төвөөр гүйцэтгүүлэн ЭБМЗ-ийн 2021.06.03-ны өдрийн ХХ-07 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.07.09-ний өдрийн А/190 дугаар тушаал батлагдсан. Боть-3-ыг товхимол болгон хэвлүүлж, 1000 ширхэгийг геологичдын хүртээл болгосон. |    |
| 33 | 2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв<br>Гүйцэтгэл: 5,056.7<br>Санхүүжилт: 5,056.7 | Үнэт, ховор, холимог металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлыг үргэлжлүүлэх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө. | ЭҮ-1-2020 болон БӨМ-Алт-2019 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.05.20-ны өдрийн А/124, А/138 дугаар тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.<br>Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх ЭҮ-2-2021, ЭҮ-3-2021 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайдын 2021.03.15-ны өдрийн тушаалаар баталсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн 2021.07.07-ны өдрийн 19, 20 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.<br>Нэмэлтээр:<br>Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж   | 90 |

|    |   |             |              |                    |  |  |     |
|----|---|-------------|--------------|--------------------|--|--|-----|
|    |   |             |              |                    |  | <p>(мөнгө, цагаан тугалга, хар тугалга-цайр, вольфрам, молибден)-ийг ХБНГУлсын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн буюу ВGR-ийн “Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь институцын болон боловсон хүчний чадавхийг хөгжүүлэх -II” төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ГУУС-ийн Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл, сургалтын төвийн эрдэмтэн, судлаачдаар гүйцэтгүүлсэн. Олон нийтийн хэлэлцүүлгийг цахимаар 2021.01.14-ний өдөр геологичдын дунд зохион байгуулсан. ЭБМЗ-ийн 2021.04.30-ны өдрийн ХХ-05 дугаар хуралдаанаар мөнгө, цагаан тугалга, хар тугалга-цайр, вольфрам, молибденийн аргачилсан зөвлөмжийг хэлэлцүүлж ХХ-05-01-ээс ХХ-05-05 дугаар зөвлөмж гарсан. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.06.11-ний өдрийн А/153 дугаар тушаал батлагдсан.</p> <p>Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр АМЕР-II-ын санхүүжилтээр бал чулуу, давс, карбонат чулуулаг, хөнгөн цагаан, лити-цези, элс хайрга, газрын ховор элементийн аргачилсан зөвлөмжийг Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл, сургалтын төвийн эрдэмтэн, судлаачдаар гүйцэтгүүлсэн. Олон нийтийн хэлэлцүүлгийг цахимаар 2021.04.07-ны өдөр геологичдын дунд зохион байгуулсан. Бал чулуу, давс, карбонат чулуулаг, хөнгөн цагаан, лити-цези, элс хайрга, газрын ховор элементийн аргачилсан зөвлөмжийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021.06.03-ны өдрийн ХХ-07 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.07.09-ний өдрийн А/190 дугаар тушаал батлагдсан. Нийт гарсан Боть-2, 3-ыг товхимол болгон хэвлүүлж, 1000 ширхэгийг геологичдын хүртээл болгосон.</p> <p>Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр АМЕР-II-ын санхүүжилтээр фосфат, манган, берилли, никель-кобальт, хромын хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмжийн төслийг 2021 оны 10 дугаар сараас эхлүүлсэн ба салбарын эрдэмтдийн оролцоотойгоор боловсруулж байна.</p> |     |
| 34 | 3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл | 2021 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | Төсөв тусгагдаагүй | Ашигт малтмалын хайгуулын 50-70 тусгай зөвшөөрөл | УУХҮСайдын 2018 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам”-ын дагуу 2021 онд СШ-48-аас СШ-57 дугаартай 10 багц талбайг зарлаж 109 тусгай зөвшөөрөл олгон улсын төсөвт 16 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 29.6 тэрбум төгрөг   | 100 |

|    |   |   |             |                  |                    |  |   |     |
|----|---|---|-------------|------------------|--------------------|--|---|-----|
|    |   | олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө           |             |                  |                    | шинээр олгон, хайгуулын ажлыг эрчимжүүлж геологийн нөөцийг өсгөнө.                               | төвлөрүүлсэн.<br>Ашигт малтмалын хайгуулын ажлын 104 тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн алт /үндсэн/ 76,433.75 мян.тн/кг металлээр, алт /шороо/ 3,799.34 кг металлээр, мөнгө 862.01 мян.тн/тн металлээр, зэс 65,749.25 мян.тн/тн металлээр, төмөр 1,366.17 мян.тн хүдрээр, никель 15,918.09 мян.тн/тн металлээр, вольфрам 2,147.29 мян.тн/тн металлээр, кобальт 1,501.36 тн металлээр, хайлуур жонш 974.31 мян.тн металлээр, манган 97.06 мян.тн металлээр, чулуун нүүрс 195.06 сая тн, шохойн чулуу 249.8 сая.тн, дайрга 68.7 сая м3, бал чулуу 1,057.73 мян.тн, гөлтгөнө 161.22 мян.тн, занар 21,976.5 мян.м3, лити 713.15 мян.тн металлээр, стронци 831.74 мян.тн, кали 20,685.47 мян.тн металлээр, молибден 21,211.56 мян тн/тн металлээр, цагаан тугалга 290.06 тн металлээр, кварц 465.21 мян.тн, гантиг 5,274.15 мян.м3, элсэн чулуу 56,877.52 мян.м3, элс 5,740.11 мян.м3, шавар 5,736.63 мян.м3, элс-хайрга 1,627.04 мян.м3, газрын тос 1.04 сая баррель-ийг улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн.  |     |
| 35 | 3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно. | 1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгоно. | 2020 - 2022 | УУХҮЯ, УУБГ, ГБГ | Төсөв тусгагдаагүй | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажил 100%. | УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д "хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал", Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой болон бусад судалгааны тайлан, зардлын тооцооны тайлан зэргийг боловсруулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулсан. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төсөлд УУХҮСайдын 2021.04.08-ны өдрийн 01/911 дугаар албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн, УУХҮСайдын 2021.04.29-ний өдрийн 01/1130 дугаар албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. ЗГХЭГ-аас 2021.05.12-ны өдрийн ХЭГ/1287 дугаар албан бичгээр Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлгийг зохион байгуулж дахин ирүүлэхээр материалыг буцаасан. ЗГХЭГ-с ирүүлсэн чиглэлийн дагуу 2021.05.07, 2021.06.04-ний өдрүүдэд | 100 |



|    |   |             |             |                    |  |   |    |
|----|---|-------------|-------------|--------------------|--|---|----|
|    |   |             |             |                    |  | Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг Ашигт малтмал, газрын тосны газарт 2 удаа зохион байгуулсан. Журмын төслийн 2 удаагийн хэлэлцүүлэгт 18 аж ахуйн нэгжийн 48 хүн оролцож санал ирүүлсэн бөгөөд саналыг судлан холбогдох өөрчлөлтийг журмын төсөлд тусган эцэслэсэн.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 1 дүгээр албан даалгаврын дагуу журмын төсөлд цахимжуулахтай холбоотой өөрчлөлтүүд орсон тул 2021 оны 11 дүгээр сард салбарын мэргэжлийн холбоодын дунд дахин хэлэлцүүлэг зохион байгуулж журмын төслийг эцэслэсэн. Энэ хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах боломжийг судлан Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран холбогдох судалгаа хийж платформ хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулсан.<br>- Дээрх чиглэл, албан даалгаврын дагуу Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтын журмын төслийг боловсруулан журам батлах эрх авахаар УУХҮ-ийн Дэд сайдын 2021.12.03-ны өдрийн 02/3005 албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Журмын төслийг 2021.12.14-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шинэчилсэн журам батлах эрх шийдвэрлэгдсэн. |    |
| 36 | 2. Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно. | 2020 - 2024 | УУХҮЯ, УУБГ | Төсөв тусгагдаагүй | Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгуулах асуудлыг шийдвэрлүүлнэ 50%-д хүргэнэ. | Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөл болон төрийн өмчит аж ахуйн тооцоот газрын дүрмийн төсөл, холбогдох тооцоо, судалгаа, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна. Мөн Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах асуудлаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тодорхой тусган оруулсан.  | 50 |
| 37 | 3. Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна.   | 2021 - 2024 | УУХҮЯ, УУБГ | Төсөв тусгагдаагүй | Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах                                | Орон нутагт эрдэс баялгийн нэгж байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Өмнөговь, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон аймгуудад байгуулахаар "Зарим аймагт Эрдэс баялгийн нэгж байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар  | 50 |

|    |  |   |             |   |                    |   |  |    |
|----|--|---|-------------|---|--------------------|---|--|----|
|    |  |   |             |   |                    | асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ 50%-д хүргэнэ.   | хэлэлцүүлэхээр хүргүүлсэн бөгөөд Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг заавал авсны дараа хэлэлцүүлэхээр буцаасан. Сангийн яамны саналыг үндэслэн дахин боловсруулж хүргүүлсэн. 2022 оны төсвийн тухай хуульд Эрдэс баялгийн хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардалд УУХҮСайдын багцад 1,0 тэрбум төгрөг тусгагдсан.  |    |
| 38 |  | 4. Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, УУБГ, ГБГ  | Төсөв тусгагдаагүй | Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийн судалгаа гаргана. Мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэх санал боловсруулна. | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 2021 оны ажиллах хүчний мэдээлэл болон уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тухайн төслийн техник, технологийн шаардлагаас хамаарсан шаардлагатай мэргэжлийн инженер, техникийн гадаад ажиллах хүчний мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Геологийн салбарын ажил мэргэжлийн ангиллыг багцалж, мэргэжлийн нэр, нэршил, ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэх үүрэг, хууль эрх зүйн болон нийгэм эдийн засгийн үндэслэл бүхий тайлбар саналыг нэгтгэн ХНХЯ-нд хүргүүлэхээр Монголын Геологийн Холбоодын Нэгдсэн Зөвлөлийн даргын 02/21 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг байгуулсан. Дэд ажлын хэсэг нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх геологийн салбарын мэргэжлийн нэр, индекс, тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, түүнчлэн геологийн салбар дахь ажил мэргэжлийн ангилалд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг /YAMAT-08/ тусгуулахаар ТНБДаргын 2021.05.09-ны өдрийн 034/21 дугаар албан бичгийг ХНХЯ-д хүргүүлсэн. | 90 |
| 39 | 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ: | 1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна.   | 2021 - 2024 | УУХҮЯ, "Кью эс си" ХХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК |                    | Төслийн удирдлага, инженеринг, тоног төхөөрөмжийн худалдан авалт. 8.9%  | Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК-ийн хэрэгжүүлж байгаа төслийн технологи өөрчлөгдөх нөхцөл байдал үүсч өмнө сонгосон технологиос хөрөнгө оруулалт болон цахилгаан эрчим хүчний зарцуулалт 2-3 дахин багатай технологи болох Мини домен зуух бүхий гангийн үйлдвэр байгуулах "Монгол ган цогцолбор 1" төслийн ТЭЗҮ-ийг шинээр боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох "MCC-CERI" компаниар /712.5 сая төгрөг/ гүйцэтгүүлж, 2021.09.30-ны өдрийн УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан. ТЭЗҮ-д тусгаснаар "Монгол ган цогцолбор 1" үйлдвэрийг нийт 507,3 сая.ам.доллар буюу 1,445.8 тэрбум төгрөгийн   | 30 |

|    |  |             |                          |  |   |   |  |
|----|--|-------------|--------------------------|--|---|---|--|
|    |  |             |                          |  |   | <p>хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд барьж байгуулан, ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Үйлдвэр ашиглалтад орсноор жилд 350 мян.тн ган бүтээгдэхүүн /жилд арматур-200 мян.тн, круг-80 мян.тн, булан төмөр-40 мян.тн, төмөр утас-30 мян.тн/ үйлдвэрлэж дотоодын гол нэр, төрлийн ган бүтээгдэхүүний хэрэгцээний 30-50%-ийг хангах, төмрийн хүдэр, баяжмалыг түүхийгээр экспортлохыг бууруулах боломж бүрдэх юм.</p> <p>Төслийг ЕРС гэрээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 2021 онд багтаан гэрээлэгчийг сонгон шалгаруулж, 2022 онд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p>"Бэрэн групп" ХХК нь 2014 оноос 200 мян.тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх домен зуух-хүчилтөрөгчийн конвертор-цахилгаан нуман зуух-шанаган зуух-тасралтгүй цутгах машин-цувих гэсэн тасралтгүй ажиллагаатай ган үйлдвэрлэлийн циклийг бий болгох зорилгоор Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж байгаа ба төслийн хэрэгжилт 70 орчим хувьтай байна.</p> <p>Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар буюу нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.</p> <p>Цаашид үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банканд гаргасан ба тус банкнаас боломжит хувилбарыг судалж байна.</p> <p>Одоогийн байдлаар өмнө авсан зээлийн хүүг төлж байгаа ба үндсэн зээлийн эргэн төлөлтийг 2022 онд хийх графиктай ажиллаж байна.</p> <p>Мөн ковид-19 цар тахлын улмаас гадаад хөрөнгө оруулалт авах талаар төлөвлөсөн гадаадад хэлэлцээр, айлчлал, БНХАУ-аас мэргэжилтэн оруулж ирэх асуудал хойшилж байгаа нь төслийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.</p> |  |
| 40 | 2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад | 2020 - 2022 | УУХҮЯ, "Бэрэн групп" ХХК | Барилга, дэд бүтцийн ажлыг дуусгаж тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралт, | <p>"Бэрэн групп" ХХК нь 2014 оноос 200 мян.тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх домен зуух-хүчилтөрөгчийн конвертор-цахилгаан нуман зуух-шанаган зуух-тасралтгүй цутгах машин-цувих гэсэн тасралтгүй ажиллагаатай ган үйлдвэрлэлийн циклийг бий болгох зорилгоор Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж байгаа ба</p> | 70  |  |

|    |  |  |             |                   |  |   |    |
|----|--|--|-------------|-------------------|--|---|----|
|    |  | оруулна.   |             |                   | суурилуулалтын ажлыг гүйцэтгэнэ. 100%  | <p>төслийн хэрэгжилт 70 орчим хувьтай байна.</p> <p>Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар буюу нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.</p> <p>Цаашид үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банканд гаргасан ба тус банкнаас боломжит хувилбарыг судалж байна.</p> <p>Одоогийн байдлаар өмнө авсан зээлийн хүүг төлж байгаа ба үндсэн зээлийн эргэн төлөлтийг 2022 онд хийх графиктай ажиллаж байна.</p> <p>Мөн ковид-19 цар тахлын улмаас гадаад хөрөнгө оруулалт авах талаар төлөвлөсөн гадаадад хэлэлцээр, айлчлал, БНХАУ-аас мэргэжилтэн оруулж ирэх асуудал хойшилж байгаа нь төслийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Мөн үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх, "Бэрэн групп" ХХК, түүний охин компани болох "Бэрэн металл" ХХК-ийн Монгол Улсын Хөгжлийн банкны нэмэлт санхүүжилтээр Орхон аймагт хэрэгжүүлж буй дээрх төслийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон технологийн өдөр тутмын хяналтыг хийх зорилгоор "Бэрэн металл" ХХК-ийн удирдлагыг Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлсэн тохиолдолд бүх талаар нээлттэй хамтын ажиллагааг өргөжүүлж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор 2021.12.28-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, нөгөө талаас Монгол Улсын Хөгжлийн банк ХХК хооронд "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулаад байна. Цутгуурын цехийн тоног төхөөрөмжийн захиалгыг хийж, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх ажил явагдаж байна.</p> |    |
| 41 |  | 3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна. | 2020 - 2023 | УУХҮЯ, "МДМУ" ХХК | Өртөөнөөс үйлдвэрийн талбай хүрэх авто зам, дотор авто зам барих, домен зуухны угсралтын ажлыг гүйцэтгэнэ. 56% | <p>МДМУ ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил ковид-19 цар тахлын улмаас 2020 оноос 2021 оны 10 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна.</p> <p>Төслийн санхүүжилт толгой компани /"Монзол групп" ХХК/-ийн хөрөнгө оруулалтаар шийдэгдсэн. Цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж, 3.567 тэрбум төгрөгийн урьдчилгааг төхөөрөмж нийлүүлэгч компанид төлсөн боловч</p>   | 50 |



|    |   |             |                                |  |  |  |    |
|----|---|-------------|--------------------------------|--|--|--|----|
|    |   |             |                                |  |  | төлөвлөгөөний дагуу БНХАУ /"Qianxi ADI Mechanical Casting" Co.Ltd компани/-д очиж газар дээр нь тоног төхөөрөмжийн сонголт хийн оруулж ирэх, мөн мэргэжилтэн оруулж ирэх асуудал хилийн хөл хорионы улмаас шийдэгдэхгүй байна. 2020 оноос хойш ковид-19 цар тахлын улмаас төслийн ажил зогссон. Цутгуурын цех, домен зуух, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмжийн захиалгын урьдчилгаа 3.567 тэрбум төгрөгийг үйлдвэрлэгч компанид төлж тоног төхөөрөмжийн татан авалтыг эхлүүлээд байна.   |    |
| 42 | 4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулна. | 2020 - 2022 | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ  |  | Зураг төсөл боловсруулах, ҮТП-ийн авто зам, дулаан, ус хангамж, цахилгаан хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээг барих ажлыг эхлүүлнэ. 30% | Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2020.12.15-ны өдөр, техник технологийн түвшний үнэлгээг 2020.09 сард, БОННУ-ий тайланг 2021.02.09-ний өдөр тус тус холбогдох мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021.07.01-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор тус паркийг байгуулах зорилгоор нийт 1217,4 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжсэн. Үүний дагуу парк байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг УУХҮСайдын 2021.07.08-ны өдрийн 01/1764 дугаар албан бичгээр БХБЯ-нд хүргүүлээд байна. УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн боловсруулах үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу дэд бүтцийн нарийвчилсан зураг, төсөл боловсруулах, барьж байгуулах ажилд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт 136.0 тэрбум төгрөгийг төсөвлөснөөс 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 4.8 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд паркийн төмөр зам, авто зам, ус хангамж, ариутгах татуургын систем барих зураг төсөл боловсруулах, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах тендерийн сонгон шалгаруулалтыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас зохион байгуулан шалгарсан этгээдтэй гэрээ байгуулан ажлын эхлүүлээд байна. | 50 |
| 43 | 5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах  | 2020 - 2024 | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, |  | ТЭЗҮ-ийн тодотгол хийх, дэд бүтцийн бүтээн   | Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл,  | 50 |

|    |   |             |   |   |   |    |
|----|---|-------------|---|---|---|----|
|    | ажлын хүрээнд Зэсийн боловсруулах үйлдвэрийг барина.  |             | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар                                | байгуулалтын ажлыг эхлүүлнэ.  | технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Уг тогтоолын 2 дахь хэсэгт зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. БНХАУ-ын China ENFI Engineering Co., Ltd (ENFI) болон China nonferrous metal industry's foreign engineering and construction Co., Ltd (NFC) консорциум нь "Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Төслийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд China ENFI Engineering компанитай 2021 оны 5-р сарын 10-ны өдөр зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн /металлургийн/ хийнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилт гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Туршилтын үр дүнд үндэслэн урьдчилсан байдлаар боловсруулагдсан ТЭЗҮ-д тодотгол хийнэ. China ENFI компани туршилтын үйлдвэр барьж байгуулах ажлын явцын талаар 2021 оны 12-р сарын 31-ний өдөр сүүлийн тайланг ирүүлсэн. Тайланд дурдсанаар зураг төслийн ажил 85%-ийн гүйцэтгэлтэй, тоног төхөөрөмжийн худалдан авалт 75%-тай байна. Хятад улсад цар тахлын дэгдэлтээс болж хөл хорио тогтоож, гэрээт ажлын явцыг удаашруулж, гэрээний хугацааг сунгах шаардлагатай болсныг гүйцэтгэгч компани урьдчилан мэдэгдээд байна. 2022 оны 3-р сард гэрээний хугацаа дуусна. |    |
| 44 | 6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна. | 2020 - 2022 | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | Үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, тусгай зөвшөөрөл авах. | Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Уг тогтоолын 2 дахь хэсэгт исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. "SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил" зөвлөх  | 50 |

|    |  |             |                                 |   |  |  |  |
|----|--|-------------|---------------------------------|---|--|--|--|
|    |  |             |                                 |   |  | <p>үйлчилгээний сонгон шалгаруулалтыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас зохион байгуулж, "Майнинг шорт лонг терм" ХХК-тай 2021 оны 9-р сарын 17-нд гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч байгууллагын мэргэжилтнүүд Эрдэнэт үйлдвэр дээр ажиллаж туршилтын дээж авч ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Гэрээний үргэлжлэх хугацаа 6 сар болно. Мөн Катодын зэс үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийг хийж гүйцэтгэж буй "MSLT" ХХК эхлэлийн тайлангаа ирүүлээд байгаа бөгөөд тус компанийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж хамтран ажиллах ажлын хэсэг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн А/585 тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсгэг 2021 оны 11-р сарын 12-ны өдөр цахимаар хуралдсан. 2021 оны 12-р сарын 5-нд эхний шатны ажлын явцын тайланг хүлээж авсан. Гэрээний заалтын дагуу гүйцэтгэлийн 30%-ийн санхүүжилт шилжүүлсэн.</p> |  |
| 45 | 7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, "Эрдэнэс Алт ресурс" ХХК | Төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ. | <p>Монгол Улсын Засгийн Газрын 2020.06.01-ний өдрийн 212 дугаар тогтоолоор ашигт малтмал хайх эрх олгогдсон ба тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020.08.26-ны өдрийн 308 дугаар шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших Хүрэнцав нэртэй 1704.51 гектар, Мухар хар толгой нэртэй 4313.57 гектар, Довжоот нэртэй 1393.37 гектар, Халзан нэртэй 453.89 гектар талбай нийт 7865.34 гектар талбай бүхий 4 тусгай зөвшөөрлийг олгосон бөгөөд эдгээр талбайг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төслийн тодорхой хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх зорилгоор Хүрэнцав нэртэй талбайд геологийн эрэл хайгуул, геофизикийн ажил гүйцэтгэх тендер зарлан ажиллаж байна.</p> <p>Компанийн эзэмшлийн хайгуулын тусгай зөвшөөрлийг барьцаалан зээл олгох боломжийн талаар арилжааны банкуудад хандсан бөгөөд арилжааны банкуудаас хайгуулын тусгай зөвшөөрөл барьцаалан зээл олгох боломжгүй тухай хариу ирүүлсэн.</p> <p>БНКазУ-ын Сымбат инженеринг компанийн боловсруулсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.</p> | 30   |  |

|    |   |  |             |                 |  |  |    |
|----|---|--|-------------|-----------------|--|--|----|
|    |   |  |             |                 |  | Мөн үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төсөлд оролцох саналаа илэрхийлсэн БНХАУ-ын уул уурхайн тоног төхөөрөмжийн Шинхай компанийн төлөөлөлтэй төслийн хөрөнгө оруулалт, хүчин чадал, өртөг зардлын талаар цахим уулзалтыг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар санал солилцсон.  |    |
| 46 |   | 9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2028 | УУХҮЯ           | Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах. Төмөр зам, эрчим хүч, ус хангамж, гадаад бүтцийн ТЭЗҮ, техникийн нөхцлийн бэлтгэл ажлыг хангана. 0.5% | Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг УУХҮСайд, Сангийн сайд, Үндэсний хөгжлийн газрын даргад тус тус даалгасны дагуу “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал” болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг олон улсад мөрдөгдөж байгаа жишиг аргачлалын дагуу боловсруулсан бөгөөд хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газрын төлөөллийг оролцуулан байгуулж, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах ажлыг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>“Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын ерөнхий сайдын 2021 оны 1 дүгээр албан даалгаврын 12.4-т заасны дагуу “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулан УУХҮСайдын 2021.11.04-ний өдрийн 01/2698 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна. | 30 |
| 47 | 3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж | 1.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг     | 2020 - 2024 | УУХҮЯ,<br>АМГТГ | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. ГТ-ны олборлолт 836.4 мян.тн  | Газрын тосны хайгуулын талбайд БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй “Метан газ ресурс” ХХК, “Жи Өү Эйч” ХХК, “Түмэн ойл” ХХК, “Смарт-ойл монголиа” ХХК, “Зон Хэн Юу Тиан” ХХК, “Монголын Алт” ХХК болон “Петровис ресурс” ХХК-иудын 2021 оны жилийн хайгуулын ажлын хөтөлбөр төсвийг баталсан ба эдгээр гэрээлэгчид 2021 онд хайгуулын ажилд нийт 40,676,116.37 ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн.   | 90 |



|    |            |  |             |              |  |   |    |
|----|------------|--|-------------|--------------|--|---|----|
|    | байгуулна: | өсгөнө.  |             |              |  | <p>Хайгуулын ажилд 3 сая долларын хөрөнгө оруулалт зарцуулсан.</p> <p>Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн, УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн "Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай" А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг "баталгаат (1P)" зэрэглэлээр 1 151 194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137 931.0 тонн (1.04 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай (2P)" зэрэглэлээр 3 051 724.0 тонн (23.01саябаррель)-оор, "баталгаат + магадлалтай + боломжтой (3P)" зэрэглэлээр 5 385 942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн.</p> <p>Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 1 талбайд нүүрсний давхаргын метан хийн, 1 талбайд газрын тосны эрлийн гэрээ байгуулсан.</p> <p>Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн 203 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Гурвантэс-ХХХV талбайд уламжлалт бус газрын тосны /нүүрсний давхаргын метан хий/ үйл ажиллагаа явуулах БХГ-г "Тэлмэн Ресурс ХК"-тай эрхийг АМГТГ-т олгосны дагуу 2021.07.27-ны өдөр БХГ-г байгуулсан.</p> <p>"Петроматад" ХХК-ийн хайгуулын ажлын үр дүнд Матад 20 талбайд Цэнтоторуу блокийг ялгаж тус блокт тогтцын магадтай 8,68 сая.бар, ашиглалтын магадтай 1,04 сая.бар газрын тосны нөөцийг тооцоолж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.</p> |    |
| 48 |            | 1.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | <p>Газрын тосны хайгуулын талбайдад БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй "Метан газ ресурс" ХХК, "Жи Өү Эйч" ХХК, "Түмэн ойл" ХХК, "Смарт-ойл монголиа" ХХК, "Зон Хэн Юу Тиан" ХХК, "Монголын Алт" ХХК болон "Петровис ресурс" ХХК-иудын 2021 оны жилийн хайгуулын ажлын хөтөлбөр төсвийг баталсан ба эдгээр гэрээлэгчид 2021 онд хайгуулын ажилд нийт 40,676,116.37 ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн.</p> <p>Ковид цар тахлын нөхцөл байдлын улмаас хил, гааль нээгдээгүй байгаатай холбоотойгоор хүн хүч, техник тоног төхөөрөмж орж ирэх боломжгүй байгаа тул ихэнх</p>   | 70 |

|    |  |             |                 |  |  |  |     |
|----|--|-------------|-----------------|--|--|--|-----|
|    |  |             |                 |  |  | гэрээлэгчдийн хайгуулын ажил хийгдэх боломжгүй болсон. Газрын тосны хайгуулын Матад-XX талбайн гэрээлэгч "Петроматад" ХХК, Онги-V талбайн гэрээлэгч "Капкорп Монголиа" ХХК, Тариач-XV талбайн гэрээлэгч "Чайна Голден Сий Петролиум Эксплорэйшн Корпорэйшн" ХХК, Арбулаг-XXIX талбайн гэрээлэгч "Макс ойл" ХХК-иуд 2021 оны төлөвлөгөө, төсвийг батлуулахаар ирүүлээгүй. Харин "Жи Өү Эйч" ХХК дотоод нөөц бололцоог ашиглан хайгуулын өрөмдлөгийн ажлыг 2021.03.08-ны өдрөөс эхлүүлсэн ба 2021.12.10-ний өдрийн байдлаар хайгуулын 14 цооног өрөмдөж дууссан ба 3 цооногийн өрөмдлөгийн ажил явагдаж байгаа ба өрөмдлөгийн ажлыг "Эрдэнэ дриллинг" ХХК, "Топ даймонд дриллинг" ХХК-иуд гүйцэтгэж байна. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт 519 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил гүйцэтгэсэн ба туслан гүйцэтгэгчээр "Бичил сейсм" ХХК ажилласан. Гэрээлэгч дээрх ажлуудад нийт 3 сая гаруй ам.доллар зарцуулсан байна. 2020 онд хайгуулын ажилд 1.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж байсан.   |     |
| 49 | 1.3. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ | 2020 - 2024 | УУХҮЯ,<br>АМГТГ |  | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. | АМГТГ-аас 2020.12.30-ны өдрийн 03/5769 дугаар албан бичгээр ирүүлсэн уламжлалт бус газрын тосны хайгуулын Гурвантэс-XXXV талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талаар АМГТГ болон Тэлмэн Ресурс ХК-ийн хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг хянаж үзэж, бичиг баримтын бүрдлийг хангуулах ажлыг зохион байгуулсан. Тус БХГ байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Засгийн тогтоолын төсөл, БХГ-ний төсөлд санал авах тухай 2021.02.23-ны өдрийн 01/388 дугаар албан бичгийг бүх яамдад явуулсан. Сангийн сайдаас БХГ-ний нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах тухай санал ирүүлсэнтэй холбоотойгоор гэрээлэгч буюу хөрөнгө оруулагч талтай Гэрээний үлдсэн нөхцлийг сайжруулах талаар хэлэлцээр хийж, БХГ-ний төслийг дахин ирүүлэх тухай 2021.05.11-ний өдрийн 01/1239 дугаар албан бичгийг АМГТГ-т явуулсан ба АМГТГ нь хөрөнгө оруулагч талтай дахин хэлэлцээр хийж, 2021.05.25-ны өдрийн 3/2188 албан бичгээр БХГ-ний төслийг дахин ирүүлсэн. Тус БХГ-ний төслийг хянан, бүх яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн 203 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Гурвантэс-XXXV талбайд | 100 |

|    |  |             |                 |  |   |   |     |
|----|--|-------------|-----------------|--|---|---|-----|
|    |  |             |                 |  |   | уламжлалт бус газрын тосны /нүүрсний давхаргын метан хий/ үйл ажиллагаа явуулах БХГ-г "Тэлмэн Ресурс ХК"-тай эрхийг АМГТГ-т олгосны дагуу 2021.07.27-ны өдөр БХГ-г байгуулсан. Мөн Засгийн газрын 2021.08.25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор Газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайг газрын тосны хайгуулын ажиллагаа явуулах зорилгоор "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д олгуулсан. Уг талбайг төрийн өмчит компанид олгосон тул бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахгүй болно.  |     |
| 50 | 1.4. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна  | 2020 - 2024 | УУХҮЯ,<br>АМГТГ |  | Хайгуулын 1 талбайд нөөц тогтоосон байна. | Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн, УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн "Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай" А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг "баталгаат (1P)" зэрэглэлээр 1 151 194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137 931.0 тонн (1.04 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай (2P)" зэрэглэлээр 3 051 724.0 тонн (23.01 сая баррель)-оор, "баталгаат + магадлалтай + боломжтой (3P)" зэрэглэлээр 5 385 942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн.   | 100 |
| 51 | 1.5. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ | 2020 - 2024 | УУХҮЯ,<br>АМГТГ |  | ГТ-ны олборлолт 836.4 мян.тн              | Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар энэ онд 812 мянган тонн газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт 183,2 тэрбум төгрөг төвлөрүүлэх даалгавартайгаас 2021.01.01-2021.12.01-ний хооронд нийт 628,854 тонн газрын тос олборлож, 590,878 тонн түүхий тос БНХАУ-д экспортлоод байна. Газрын тосны орлогоос 2021.11.30-ны өдрийн байдлаар 180,5 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.<br>БХГ-ний дагуу газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниуд газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө, төсвийг ирүүлсэн.<br>Газрын тосны ашиглалтын БХГ-97 талбайн гэрээлэгч Доншен Газрын тос (Монгол) ХХК-ийн 2021 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2021.05.12-ны өдөр, Тосон-Уул XIX, Тамсаг ХХI талбайн гэрээлэгч Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2021 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2021.05.25-ны | 90  |

|    |   |             |              |  |   |   |     |
|----|---|-------------|--------------|--|---|---|-----|
| 52 | 2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ |  | Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, Трассын дагуух газрын тусгай хэрэгцээнд авсан байна.ТЭЗҮ-ийг хүлээн авсан байна.10% | өдөр тус тус хэлэлцэн баталсан.<br>ЗГ-ын 2020.01.06-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тэмдэглэлээр Монгол-газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэх нь зүйтэй гэж шийдвэрлсэн. 2020.02.19-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, худалдан авалтыг зохион байгуулах, бүтээн байгуулалтыг зохион байгуулахыг Сангийн сайд, УУХҮСайд нарт тус тус даалгасан. Санхүүжилтийн асуудлыг шийдүүлэх талаар СЯ-нд удаа дараа хандсан. Мөн УУХҮСайдын 2020.10.23-ны өдрийн А-267 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулж дамжуулах хоолойн трассыг ГХГЗЗГ-ын мэдээллийн сангийн нууцын талбарт бүртгүүлж, трассын дагуух зурвас газрыг тусгай хэрэгцээнд авах хүсэлт, холбогдох материалыг БХБЯ-нд НУУЦ-ын бичгээр хүргүүлээд байна. ЗГ-ын 2020.12.09-ний өдрийн хуралдаанаар төслийг санхүүжүүлж барьж байгуулах олон улсын сонгон шалгаруулах талаар 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Сонгон шалгаруулалтыг EPC+F буюу санхүүжүүлж барьж байгуулах нөхцлөөр явуулсан тул ТЭЗҮ боловсруулж хүлээн авах шаардлагагүй болсон. | 70  |
| 53 | 2.3. Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна    | 2020 - 2024 | УУХҮЯ        |  | ТЭЗҮ-ийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ТЭЗҮ-ийг хүлээн авсан байна. 10%   | УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.01.25-ны өдрийн А/08-р тушаалаар төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулж Үнэлгээний хороо урьдчилсан сонголтын зарыг "Pipeline and Gas Journal" сэтгүүл болон веб сайтад нийтэлж 2021.04.23-ны өдөр тендерийн баримт бичгийг хүргүүлсэн. Цар тахлын нөхцөл байдлын улмаас тендерт оролцогчдоос ирүүлсэн удаа дараагийн хүсэлтийг харгалзан тендер ирүүлэх хугацааг нийт 4 удаа сунгаж 2021.10.23-ны өдөр тендерийг нээж техникийн болон санхүүгийн саналыг үнэлэн гүйцэтгэх компанийг шалгаруулж компанитай байгуулах гэрээний нөхцөл, гэрээний төслийг боловсруулж байна. Шалгаруулалтыг EPC+F буюу санхүүжүүлж барьж байгуулах нөхцлөөр явуулсан тул ТЭЗҮ боловсруулж хүлээн авах шаардлагагүй болсон.  | 100 |
| 54 | 3.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд   | 2020 - 2024 | УУХҮЯ        |  | Лицензгүй болон үйлдвэрийн хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн   | Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын ерөнхий гүйцэтгэгч Жэй Эм Си Прожектс лимитед компани 2020.01.15-ны өдөр үйлдвэрийн талбайн ажлыг эхлүүлсэн. EPC-1 багц ажлын зураг төслийн ажил 90%, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2021.12.07-ны өдрийн байдлаар 36,0%-тай байна. Мөн Бор хөөврийн говиос ус дамжуулах   | 70  |



|    |   |             |       |   |  |     |
|----|---|-------------|-------|---|--|-----|
|    | тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.  |             |       | цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн байна. Мөн Лицензит байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. 25% | шугам хоолойн ажлууд болох өргөх станцын барилга-31,4%, 11 ширхэг худгийн барилга-31,3%, ус нөөцлөх савны барилга-65,1%, ЦДАШ-22,1%, ус дамжуулах хоолой-17,2%, үйлдвэрийн хашаан доторх авто зам-22,6%, зам талбайн ус зайлуулах хоолой-12,4%, зам талбайн ус хураах талбай-81,6%, замын доорх ус дамжуулах хоолой-82,4, технологийн шугам хоолойн суваглал-61,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.12.30-нд хүлээн авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.05.20-нд зарласан бөгөөд цар тахлын нөхцөл байдал, ажлын цар хүрээ, тендерт оролцогч компаниудын хүсэлтийг харгалзан тендер хүлээн авах хугацааг 2022.01.28 хүртэл сунгаад байна. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын тухайд лиценз эзэмшигчдээс ирүүлсэн тендерийн техникийн хэсгийг хянах, үнэлэх ажил хийгдэж байна. |     |
| 55 | 3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна        | 2020 - 2024 | УУХҮЯ | Хууль батлагдсан байна. 100%  | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2021.01.29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Мөн хуулийн 3.3 дахь хэсэгт заасан Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг ЗГ-ын 2021.08.11-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор батлуулав.   | 100 |
| 56 | 3.3. Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг | 2020 - 2024 | УУХҮЯ | Лицензгүй болон үйлдвэрийн хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг                        | Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэг бүхий Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2021 оны 122, 133 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Шадар сайдын 2021 оны 87 дугаар тушаалаар Ажлын хэсгийн төлөвлөгөө, ШС-ын 2021.09.13-ны өдрийн 01/21 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам, газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайг   | 70  |

|    |  |             |       |  |  |   |    |
|----|--|-------------|-------|--|--|---|----|
|    | үзүүлнэ  |             |       |  | эхлүүлсэн байна. Мөн Лицензит байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. 25% | Үйлдвэрт олгох асуудлыг тус тус батлуулсан. БНХАУ-ын Тяньжин боомтод саатсан барилгын материалыг татан авах талаар ГХЯ, ЗТХЯ, БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, МГТБҮ ТӨХХК, Энэтхэгийн JMC компанитай хамтран ажиллав. Үйлдвэрийн технологийн бус барилгын ажил /ЕРС-1/-д шаардлагатай 4000 тонн бараа материал 2021.12.24-ний өдөр БНХАУ-ын Тяньжин боомтод ирж ачааг боомтын талбайд бүрэн буулгасан бөгөөд ачааг Эрээн боомт хүртэл тээвэрлэн авч ирэх ажлыг зохион байгуулж байна. Мөн бүтээн байгуулалтын явцын талаар УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021.10.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 04 дүгээр тогоол гарсан.  |    |
| 57 | 3.4. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | УУХҮЯ |  | Шатахууны хангамж тогтвортой байна. 2.1 сая тонн   | Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 175 аж ахуйн нэгж улсын хэмжээнд шатахууны 85 агуулах, 1419 шатахуун түгээх станцаар дамжуулан бүтээгдэхүүний хангамж, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ онд буюу 2021.12.31-ний өдрийн байдлаар 1,610 сая тонн ГТБ импортлон, хэрэглэснээс дизель түлш 902.9 мян.тонн, автобензин 516.3 мян.тонн, шатдаг хий 34.5 мян.тонн, ТС-1 26.7 мян.тонн тус тус байна.<br>Засгийн газрын 2020.10.07-ны 136 дугаар тогтоолоор 2021 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 24 аж ахуйн нэгж 120,350.00 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ нь эдгээр аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Улсын хэмжээнд 2021.12.06-ны өдрийн байдлаар дунджаар ердийн хэрэглээний 28 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаагаас А-80 автобензин 45, Аи-92 автобензин 39, дизелийн түлш 22, ТС-1 онгоцны түлш 22 хоногийн тус тус нөөцтэй байна.<br>Өнгөрсөн оны 11 дүгээр сараас эхлэн тодорхой хүчин зүйлсийн нөлөөллөөр дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тасралтгүй өссөн ба үүнийг дагаад ОХУ-аас манай улсад нийлүүлж буй газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ сар бүр нэмэгдэж ирсэн. Иймд өргөн хэрэглээний АИ-92 автобензиний үнийг тогтворжуулах, хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх, харилцааг зохицуулах "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам"-ыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн | 90 |

|    |   |             |       |  |  |  |     |
|----|---|-------------|-------|--|--|--|-----|
|    |   |             |       |  |  | <p>хуралдаанаар хэлэлцүүлж 68 дугаар тогтоолоор батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээний үлгэрчилсэн загвар, мэдээ тайлангийн маягтын загварыг УУХҮСайдын 2021.04.28-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан. Тус тушаал, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах тухай 2021.04.30-ны өдрийн 01/1150 тоот албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн ба журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Мөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба ЗГ-ын 74 дүгээр тогтоолоор улсын нөөцийг 30000 тонноор нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу улсын нөөцийг нэмэгдүүлэх АИ-92 төрлийн автобензиний худалдан авалтын ажлыг зохион байгуулахыг төрийн өмчит “Монгол ГТБҮ” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон “Эрчис ойл” ХХК-нд чиглэл болгосон. Үүний дагуу улсын нөөцийн 30000 тонн АИ-92 автобензинийг худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна.</p> |     |
| 58 | 3.5. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | УУХҮЯ |  | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 15%-д хүрсэн байна. | <p>Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100% импортоор хангаж байгаа бөгөөд 2021.12.31-ний өдрийн байдлаар нийт 1.56 сая.тонн шатахуун импортлон хэрэглэжээ. Үүнээс дизель түлш 988.9 мян.тонн, автобензин 572.7 мян.тонн байгаагаас К5 /Евро-5/ ангиллын стандартын автобензин 98,138 тонн, дизелийн түлш 143,430 тонн, нийт 241,568 тонныг импортолсон нь нийт шатахууны 15,5 %-ийг эзэлж байна. ОХУ-ын Роснефть компаниас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны импортын үнэ ердийн шатахууны үнээс тонн тутамдаа төрлөөс хамааран 25-60 ам.доллараар өндөр байдгаас шалтгаалан Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ литр тутамдаа 60-100 төгрөгөөр өндөр байна. Энэхүү үнийн зөрүүтэй холбоотойгоор Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээ дорвитой нэмэгдэхгүй байгаа болно.Иймд энэхүү үнийн зөрүүг арилгах зорилгоор автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай</p>  | 100 |



|    |                    |             |        |  |                       |  |     |
|----|--------------------|-------------|--------|--|-----------------------|--|-----|
|    |                    |             |        |  |                       | <p>уялдуулан ялгавартай тогтоох, өөрөөр хэлбэл хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахуунд ногдох онцгой албан татварыг экологийн бага ангиллын стандартын шатахуунаас тодорхой хувиар бага тогтоох эрх зүй, татварын орчин бүрдүүлэх шаардлага тулгарч ирсэн. Энэ хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хуулийн төслийг УУХҮСайдын 2021.02.04-ний өдрийн 01/291 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, чанар стандартын шаардлага хангахгүй шатахуун гарган авах зориулалтаар импортолж буй зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах замаар агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулах тухай УУХҮ-ийн Дэд сайдын 2021.01.12-ны өдрийн 02/67 дугаар бичгээр ОББҮХ-нд хүргүүлсэн. Дээрх асуудал ОББҮХ-ны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан ба тус чиглэлээр ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажиллаж байна. ОББҮХ-ноос агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаар Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ба Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлээр Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох, Евро-5 стандартаас доош чанартай шатахууныг жижиглэнгээр худалдан борлуулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох сайд нар болон Нийслэлийн Засаг даргад даалгасан.</p> |     |
| 59 | 3.6. Баруун бүсийн | 2020 - 2024 | УУХҮЯ, |  | БОНБНҮ-г боловсруулж, | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "Трансгейт интернэйшнл" ХХК Баруун бүсийн шатахууны хэрэглээний   | 100 |



|    |  |   |             |       |  |   |   |    |
|----|--|---|-------------|-------|--|---|---|----|
|    |  |   |             | АМГТГ |  | батлуулсан байна. 10%   | тодорхой хувийг хангах бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн, тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалттай 6 га газар эзэмших зөвшөөрөл авсан. /15 жилийн хугацаатай 2019.09.27 А246 тоот шийдвэр/, үйлдвэрийн агуулахын зураг төслийг Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон ОБЕГ, Барилгын хөгжлийн төвөөр тус тус хянан батлуулсан. Геодезийн дэвсгэр зураг боловсруулсан ба геологи инженерийн дүгнэлт гаргуулсан. Цахилгаан, эрчим хүчний зураг төслийг боловсруулсан. Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан.  |    |
| 60 |  | 3.7. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна | 2020 - 2024 | УУХҮЯ |  | Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, УИХ-д хүргүүлэх 10%. | Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэн, 2017 оны 04 сарын 04-ний өдөр "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан. Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн "Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 14 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх зорилгоор охин компани байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад даалгасан. Тус тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/81 тушаалаар "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн охин компани болох "Эрчис ойл" ТӨХХК-ийг байгуулсан ба тус компани нь Чингис хаан" олон улсын нисэх буудлын онгоцны түлшний хангамжийн үйл ажиллагааг сонирхогч талтай хамтран эрхлэх ажлыг зохион байгуулж байна. УИХ-аас Төрийн өмчит Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах болон түүхий тос дамжуулах хоолой барих үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах Газрын тос | 50 |

|    |  |   |             |                                |                                |  |    |
|----|--|---|-------------|--------------------------------|--------------------------------|--|----|
|    |  |   |             |                                |                                | <p>боловсруулах үйлдвэрт дэмжлэг үзүүлэх тухай хуулийг 2021 оны 01 дүгээр 29-нд баталсан. Тус хуульд Газрын тос боловсруулах үйлдвэр түүхий эдийн тогтвортой нөөцтэй байх зорилгоор газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж болно гэж заасан. Хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст XXXI талбайг Газрын боловсруулах үйлдвэрт олгосон. Мөн Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулан, газрын хайгуул ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар тусгасан. Дээрх хууль, журам, тогтоолын хүрээнд Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК нь газрын тосны хайгуул, ашиглалт, үйлдвэрлэл, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн нөхцөл, боломж бүрдсэн. Мөн Газрын тосны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусган боловсруулж байна.</p>  |    |
| 61 | 3.5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх | 1. Монгол улсын газар нутгаар дайруулан татах хийн хоолойн судалгааг хийнэ. | 2021 - 2024 | Эрдэнэс Монгол ХХК, УУХҮЯ, ЭХЯ | Судалгааны ажил эхэлсэн байна. | <p>Ерөнхий сайдын 2020.01.06-ны өдрийн 03 тоот захирамжаар Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Уг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна.</p> <p>ОХУ-аас БНХАУ руу Монгол улсын нутаг дэвсгэрээр дамнуулан тавих байгалийн хий дамжуулах хоолойг барьж, ашиглах, хамгаалахтай холбогдсон асуудлаар шинээр эрх зүйн орчинг бүрдүүлэхэд УУХҮЯ-наас дараахь эрх зүйн зохицуулалтыг тусгуулсан. Үүнд: Улсын хил дамнан байгалийн хий дамжуулах хоолойтой холбогдсон Монгол улсын хууль, тогтоомж эрх зүйн орчны талаар өнөөгийн байдал, Монгол Улсын хөрш орнуудтай байгуулсан хилийн дэглэмийн гэрээний асуудал зэргийг судалгааны ажилд тусгуулсан. Мөн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд хий хоолойн трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-г Тусгай зориулалтын компани “Газопровод Союз Восток” ХХК боловсруулж байна.</p> | 70 |

|    |   |  |             |                                     |                                       |  |  |    |
|----|---|--|-------------|-------------------------------------|---------------------------------------|--|--|----|
| 62 | бэлтгэл хангана.  | 2. ОХУ, БНХАУ-ыг холбосон хийн хоолой Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх трассын хувилбарыг боловсруулж, төслийн нэгжийг мэдээллээр хангана.               | 2020 - 2021 | Шадар сайдын ажлын алба, УУХҮЯ, ЭХЯ |                                       | Хийн хоолой дайран өнгөрөх трассын хувилбарыг боловсруулсан байна. | Монгол Улсын Шадар сайдаас 2020.01.28-ны өдрийн ЗГ-2/58 дугаар албан бичгээр ирүүлсэн ОХУ, БНХАУ-ыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байр зүйн зургийг бэлтгэн холбогдох материалын хамт 2020.03.05-ны өдрийн 03/646, 2020.10.27-ны өдрийн 01/2497 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан. ОХУ-аас БНХАУ руу дамжуулан барих байгалийн хийн хоолой /трассын хувилбар нь/ нь манай улсын нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг хүн ам ихээр төвлөрсөн суурьшлын бүсүүдээр дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн. | 90 |
| 63 | 3.6.3. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ.                         | 2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна. | 2021 - 2024 | ЗТХЯ, УУХҮЯ, ТХААГ, ХХ              |                                       | Цахилгаанаар цэнэглэх 12 цэг, хийгээр цэнэглэх 6 станц             | Байгалийн хийн импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч Юу Би Метан ХХК нь 2021 онд 1000 тонн шахсан байгалийн хий импортлон, нийслэлийн нийтийн тээврийн 100 орчим хийн хөдөлгүүртэй автобусыг цэнэглэх үйл ажиллагаа явуулсан. Тус компани 2021 онд Баянзүрх дүүргийн Монелд тээврийн хэрэгслийг байгалийн хий, ШШХ, шатахуунаар цэнэглэх станц барьж байгуулахаар зураг, төслийг батлуулан, эхний хэсгийг УОК-т хүлээлгэн өгсөн. Мөн Сонгинохайрхан дүүргийн Рашаант өртөөнд байгалийн хийн агуулах, хий цэнэглэх станц барих төслийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 80 гаруй хувьтай явагдаж байна.   | 50 |
| 64 | 3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр | 1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ.  | 2020 - 2024 | Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ,         | 132470.6 сая төгрөг ТӨҮГ-ын хөрөнгөөр | Барилга ажлыг бүрэн дуусгаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна.   | Бэрэн групп ХХК-ийн 2004 оноос эхлэн Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 78%-тай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас зээлийн эргэн төлөлт төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банканд гаргасан ба банкны зүгээс боломжит хувилбарыг судалж байна. Өнөөгийн байдлаар өмнө авсан зээлийн хүүг төлж, үндсэн зээлийн эргэн төлөлтийг 2022 онд хийх графиктай                | 50 |

|    |  |             |   |  |  |   |     |
|----|--|-------------|---|--|--|---|-----|
|    | дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. |             |   |  |  | ажиллаж байна. Мөн үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх, "Бэрэн групп" ХХК, түүний охин компани болох "Бэрэн металл" ХХК-ийн Монгол Улсын Хөгжлийн банкны нэмэлт санхүүжилтээр Орхон аймагт хэрэгжүүлж буй дээрх төслийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон технологийн өдөр тутмын хяналтыг хийх зорилгоор "Бэрэн металл" ХХК-ийн удирдлагыг Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлсэн тохиолдолд бүх талаар нээлттэй хамтын ажиллагааг өргөжүүлж, мэргэжлийн тусалцаа үзүүлэх зорилгоор 2021.12.28-ны өдөр Уул уурай, хүнд үйлдвэрийн яам, нөгөө талаас Монгол Улсын Хөгжлийн банк ХХК хооронд "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулаад байна.<br>Санхүүжилтийн асуудал шийдэгдсэн тохиолдолд үйлдвэрийг 2022 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.<br>Мөн ковид-19 цар тахлын улмаас гадаад хөрөнгө оруулалт авах талаар төлөвлөсөн гадаадад хэлэлцээр, айлчлал, БНХАУ-аас мэргэжилтэн оруулж ирэх асуудал хойшилж байгаа нь төслийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. |     |
| 65 | 2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.      | 2020 - 2024 | Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, НЗДТГ             |  | Шилний үйлдвэр барих төсөл боловсруулж холбогдох газарт хүргүүлнэ. | Шилний үйлдвэрийн төсөл хэрэгжүүлж буй "Эрдэс плазм" ХХК-ийн төсөлтэй БХБСайд Б.Мөнхбаатар 2021 оны 05 дугаар сарын 13-нд тус компанийн үйлдвэрийн төсөлтэй газар дээр нь очиж дахин танилцсан.<br>Мөн "Эрдэс плазм" ХХК-ийн шилний үйлдвэрийг дэмжин ажиллах бодлогын хүрээнд үйлдвэрлэл, технологийн паркын орчинд орж ажиллах боломж, давуу талыг танилцуулснаар тус компанид Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 227 дугаар тогтоолоор ҮТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг БХБЯ-наас 5 жилийн хугацаатай олгосон.  | 70  |
| 66 | 3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.    | 2020 - 2024 | Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, Ховд аймгийн ЗДТГ |  | Цементийн үйлдвэрийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.                  | Ховд эко цементийн үйлдвэрийн төслийг "Вестерн холд" ХХК хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү үйлдвэр ашиглалтанд орсноор баруун бүсийн цементийн хэрэглээг бүрэн хангах юм. Цар тахалтай холбоотойгоор төслийн ажлын явц тодорхой хугацаагаар хойшилсон ч төслийг 2021 оны IV улиралд багтаан ашиглалтад оруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар төслийн явц 70%-тай байна.<br>Ховд аймагт цементийн үйлдвэр байгуулах "Вестерн холд" ХХК-ийн хөрөнгө оруулалтыг зээлээр шийдвэрлэх талаар   | 100 |



|                                  |   |   |             |                              |  |  |     |
|----------------------------------|---|---|-------------|------------------------------|--|--|-----|
|                                  |   |   |             |                              |  | санал боловсруулж Хөгжлийн банкинд 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01/537 тоотор уламжилснаар тус төсөл Хөгжлийн банкнаас 20 сая ам.долларын зээл авч барилга угсралтын ажлаа гүйцэтгэж, барилга угсралтын бетон цутгалтын ажлын явц өнөөгийн байдлаар 97%-тай хэрэгжиж байна.<br>БНХАУ-аас 2021 онд 45 мэргэжилтэн урьж ажиллуулсан. Эдгээр гадаадын ажиллах хүч 5-6 сард ирж, барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралтын ажилд оролцсон. 2022 онд ажиллуулах Хятад ажилчдыг ирүүлэх хүсэлтийг ХНХЯ-нд уламжилсан.   |     |
| 67                               |   | 4. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ. | 2021 - 2024 | УУХҮЯ<br>Хамтрагч нь<br>БХБЯ | Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийнэ. | Эрх зүйн тусгайлсан хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн бусад холбогдох хуулиудтай зөрчил, давхардал, хийдэл байгаа эсэхийг тогтоож, тодруулах судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. Энэхүү судалгааны үр дүнд Түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой харилцааг зохицуулах тусгайлсан хууль шаардлагагүй гэдэгт тогтоогдсон байна. Иймд энэхүү асуудлыг тусган Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улмаар УИХ-д өргөн мэдүүлсэн боловч байнгын хороодоор хэлэлцэх явцад хуулийн төслийг дахин боловсруулахаар буцаасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон. Эдгээр чиглэл болон эрх зүйн өөрчлөлтүүдтэй уялдуулан Хуулийн төслийг дахин боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2020 оны А/332 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоол гарсан. | 70  |
| <b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b> |   |   |             |                              |  |  |     |
| 68                               | 4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын | 3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд   | 2021 - 2024 | Яамд, ТАЗ, УАкадеми          | Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад   | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. 2021 оны Сургалтын төлөвлөгөөндөө ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулахаар төлөвлөн албан хаагчдад ёс зүйн талаар шаардлагатай мэдээ, мэдээллийг  | 100 |

|    |  |  |             |                         |  |  |   |    |
|----|--|--|-------------|-------------------------|--|--|---|----|
|    | гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. |             |                         |  | хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ.   | тогтмол хүргэж байна. Төрийн албаны зөвлөлөөс байгууллагуудын дэргэд ёс зүйн зөвлөлүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулсан “Ёс зүйн зөвлөлүүдийг чадавжуулах нь сэдэвт” сургалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг хамруулж ажилласан. 3Г-ын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу Үнэлгээний багийг ТНБДаргын 2021.11.23-ны өдрийн А/92 дугаар тушаалаар байгуулсан. Үнэлгээний баг УУХҮЯ-ны 68 албан хаагчдын 2021 оны жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшингийн үнэлгээг хийсэн. Нийт албан хаагчдын үнэлгээний оноо 82.5-99.7 хүртэл үнэлэгдсэн байна. УУХҮЯ-ны 2021 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилгодсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч, Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугмаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 128 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2021 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. |    |
| 69 | 4.3.17. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн                                  | 1. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй   | 2020 - 2022 | УУХҮЯ, Хамтрагч нь МХЕГ |  | Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг | Улсын Их Хурал 2020.01.30-ны өдөр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан. Мөн Улсын онцгой комиссын 2020 оны 35 дугаар тэмдэглэлийн 3.6-д “уул уурхайн зориулалттай сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бараа   | 90 |

|    |  |   |             |                        |   |  |    |
|----|--|---|-------------|------------------------|---|--|----|
|    | аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.   | байдал, хяналтыг сайжруулна.  |             |                        | сайжруулна.   | <p>материалын тээвэрлэлт, түгээлтийг халдвар хамгаалалын дэглэмийг сайтар мөрдөж, ариутгал, халдваргүйжүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу аймг, нийслэл, орон нутагт саадгүй нэвтрүүлэх” заалтыг тусгуулж шийдвэрлүүлсэн. Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр ашиглах тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл олгох асуудлыг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байна. Уг тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж байна.</p> <p>Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах агуулахад тавигдах шаардлага, хадгалах үеийн аюулгүй байдалтай холбоотой харилцааг Дэд бүтцийн сайдын 2004.05.19-ний өдрийн 96 дугаар тушаалаар баталсан “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах, галын аюулгүйн норм”, Үйлдвэр худалдааны сайд болон Шадар сайд нарын 2007.05.07-ны өдрийн 90/12 дугаар тушаалаар баталсан “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савыг улсын бүртгэлд бүртгэх журам”-аар тус тус зохицуулж байна. Мөн Газрын тосны бүтээгдэхүүн нь MNS 4978:2000 стандартаар аюултай ачаанд тооцогддог бөгөөд тээвэрлэлтийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ийг дагуу гүйцэтгэдэг. АМГТГ нь газар дээрх дүрэм, журмын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдалд холбогдох байгууллагуудтай хамтран тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.</p> |    |
| 70 | 4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой | 4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр | 2021 - 2024 | УУХҮЯ, СЯ Хамтрагч ГХЯ | Үйлдвэрийг барьж байгуулахаар хэрэгжүүлж буй төсөлд тодорхой ахиц гарсан байна. | Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд технологийн зарим байгууламжийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилсан сонгон шалгаруулалт болон гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгох ажлууд дуусах шатанд байна. Уг ажлуудыг төслийн менежментийн зөвлөх БНЭУ-ын Engineers India Limited компанитай хамтран гүйцэтгэж байгаа ба зөвлөхөөр буюу “Захиалагчийн инженер”-ээр Итали улсын “Prometheus” компани ажиллаж байна. Үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжын ажил /EPC-1/-ыг гүйцэтгэх Энэтхэгийн JMC Projects India компанийг шалгаруулж, 2020.10.13-ны өдөр гэрээг байгуулан барилга угсралтын  | 70 |

|                                     |   |   |             |                                  |   |  |  |    |
|-------------------------------------|---|---|-------------|----------------------------------|---|--|--|----|
|                                     | "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана. | байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.                      |             |                                  |   |  | ажлыг эхлүүлээд байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Эксим банк, Төслийн менежментийн зөвлөх /ТМЗ/ компанитай зөвшилцсөний үндсэн дээр үндсэн 4 хэсэгт хуваан хэрэгжүүлж байгаа ба эдгээрт:<br>ЕРС-1: Технологийн бус барилга байгууламж<br>ЕРС-2: Анхдагч процессийн болон дагалдах байгууламж<br>ЕРС-3: Үйлдвэрийн цахилгаан станц<br>ЕРС-4: Лицензит технологийн байгууламж<br>Тайлбар: (ЕРС: Инженерчлэл-худалдан авалт-барилга-угсралт)<br>Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэг бүхий Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2021 оны 122, 133 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Шадар сайдын 2021 оны 87 дугаар тушаалаар Ажлын хэсгийн төлөвлөгөө, ШС-ын 2021.09.13-ны өдрийн 01/21 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам, газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайг үйлдвэрт олгох асуудлыг тус тус батлуулсан. БНХАУ-ын Тяньжин боомтод саатсан барилгын материалыг татан авах талаар ГХЯ, ЗТХЯ, БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, МГТБҮ ТӨХХК, Энэтхэгийн JMC компанитай хамтран ажиллав. Үйлдвэрийн технологийн бус барилгын ажил /ЕРС-1/-д шаардлагатай 4000 тонн бараа материал 2021.12.24-ний өдөр БНХАУ-ын Тяньжин боомтод ирж ачааг боомтын талбайд бүрэн буулгасан бөгөөд ачааг Эрээн боомт хүртэл тээвэрлэн авч ирэх ажлыг зохион байгуулж байна. Мөн бүтээн байгуулалтын явцын талаар УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021.10.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 04 дүгээр тогоол гарсан. |    |
| <b>ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b> |   |   |             |                                  |   |  |  |    |
| 71                                  | 5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8  | 1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ, АНЗДТГ, БОАЖЯ<br><br>МХЕГ | 84,0 сая төгрөгөөр Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | 2021.04.09-2021.04.12-ны өдөр нийт 4 хоног Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг Ялбаг, Бугант тосгонд уул уурхайн болон бичил уурхай, хууль бус олборлолтын улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайд эвдэрсэн газрын тооллого хийх зорилгыг хэрэгжүүлэн ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоолын 3, 2019 оны 355 дугаар тогтоолын 1.4 дэх заалтын хэрэгжилтийг  | 70 |



|    |   |  |             |   |  |  |    |
|----|---|--|-------------|---|--|--|----|
|    | мянган га<br>талбайг<br>нөхөн<br>сэргээнэ.  |  |             |   |  | <p>хангах зорилгоор хяналт шалгалтыг зохион байгуулахад “Ялбаг” гэх газарт экскаватор 20, ковш 7, ачааны машин 4, алт угаах төхөөрөмж 12, “Харганат” гэх газарт экскаватор 9, ковш 6, алт угаах төхөөрөмж 2, “Өлөнт” гэх газарт экскаватор 7, ковш 3, “Хорийн даваа” гэх газарт экскаватор 10, алт угаах төхөөрөмж 2 нийт 82 техник хэрэгслийг ууланд нуусан болон нутгийн иргэдийн гадна байрлуулсан байсныг бүртгэлжүүлж 5 хэсэг газарт нэгтгэн байрлуулж, 77 техник хэрэгслийн эзэмшигчийг тогтоож, тус аймаг дахь Цагдаагийн газрын дарга, сумын удирдлагад уулнаас татан буулгах, дахин хууль бусаар ашигт малтмал олборлуулахгүй байх ажил арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэл өгсөн.</p> <p>Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн 2021 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 202 аж ахуйн нэгжийн 1,782 га талбай, 2917.9 сая.төгрөгийг дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд зарцуулахаар төлөвлөсөн байна. Зарим ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөвлөгөөнд орон нутгийн Байгаль орчны газраас дүйцүүлэх нөхөн сэргээлт хийх талбайг зааж өгөөгүйн улмаас зөвхөн зардлын хэмжээ тавигдсан байгаа тул тус тоо ашиглалтын үйл ажиллагааны тайлангийн мэдээлэлд өөрчлөгдөх магадлалтай. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дугаар заалтын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны тайланг ирүүлэх хугацаа дараа жилийн 2 дугаар сарын 15 тул хэрэгжилтийг бүрэн гаргах боломжгүй.</p> |    |
| 72 | 5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар | 2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана. | 2020 - 2024 | БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, СЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ<br><br>ОБЕГ, АНЗДТГ, ҮХГ | Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулна. | <p>Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр, зорилт арга хэмжээг тодорхойлох баримт бичгийг боловсруулах үүрэг бүхий Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт тус яамнаас холбогдох албан тушаалтнууд ажилласан болно. Ажлын хэсгээс Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд өчүүхэн (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их байгааг тогтоосон. Мөн 2014 онд нийт 34482.73 мян.тн CO2 ялгаруулсны 50.08% нь эрчим хүч, 48.51% нь хөдөө аж ахуй, 0.95% нь аж үйлдвэр, үлдсэн 0.46 нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгаралд 2020 онд нүүрсий олборлолт 4.9%-ийг эзэлж байна. Дээр дурдсан баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээнд нүүрсний</p>  | 70 |

|            |  |  |  |  |  |  |
|------------|--|--|--|--|--|--|
| бууруулна. |  |  |  |  |  | <p>уурхайн метан хийг ашиглах асуудлыг 2025-2030 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан болно. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг УУХҮСайдын 2020.11.25-ны өдрийн 01/2909 дүгээр албан бичгээр Сангийн яам болон ХЗДХЯ-нд, агаарын чанарыг сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох талаар Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг УУХҮСайдын 2020.09.24-ний өдрийн 01/2345 тоот албан бичгээр БОАЖЯ-нд тус тус хүргүүлсэн.</p> <p>Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100% импортоор хангаж байгаа бөгөөд 2021.12.03-ны байдлаар нийт 1.4 сая.тонн шатахуун импортлон хэрэглэжээ. Үүнээс дизель түлш 902.9 мян.тонн, автобензин 516.3 мян.тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин 37,233 тонн, дизелийн түлш 120,019 тонн, нийт 157,252 тонныг импортолсон нь нийт шатахууны 12%-ийг эзэлж байна. ОХУ-ын Роснефть компаниас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны импортын үнэ ердийн шатахууны үнээс тонн тутамдаа төрлөөс хамааран 25-60 ам.доллараар өндөр байдгаас шалтгаалан Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ литр тутамдаа 60-100 төгрөгөөр өндөр байна. Энэхүү үнийн зөрүүтэй холбоотойгоор Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээ дорвитой нэмэгдэхгүй байгаа болно. Иймд энэхүү үнийн зөрүүг арилгах зорилгоор автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, өөрөөр хэлбэл хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахуунд ногдох онцгой албан татварыг экологийн бага ангиллын стандартын шатахуунаас тодорхой хувиар бага тогтоох эрх зүй, татварын орчин бүрдүүлэх шаардлага тулгарч ирсэн. Энэ хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хуулийн төслийг УУХҮСайдын 2021.02.04-ний өдрийн 01/291 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд Орчны</p> |
|------------|--|--|--|--|--|--|

|                       |  |  |  |  |  |  |   |             |
|-----------------------|--|--|--|--|--|--|---|-------------|
|                       |  |  |  |  |  |  | <p>бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, чанар стандартын шаардлага хангахгүй шатахуун гарган авах зориулалтаар импортолж буй зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах замаар агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулах тухай УУХҮ-ийн Дэд сайдын 2021.01.12-ны өдрийн 02/67 дугаар бичгээр ОББҮХ-нд хүргүүлсэн. Дээрх асуудал ОББҮХ-ны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан ба тус чиглэлээр ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажиллаж байна.</p> |             |
| <b>ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН</b> |  |  |  |  |  |  |   | <b>77.7</b> |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2022.01.17